



“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ



Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн тайлан



Явцын тайлан: 2018 оны 4-р сар



Баримт бичгийн дугаар 13-391-N13. Хувилбар 0. - 2018 оны 7-р сар

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн тайлан
Явцын тайлан: 2018 оны 4-р сар

Тайлангийн хувилбар	Гарсан огноо
I төсөл	2018 оны 5-р сарын 28
II төсөл	2018 оны 6-р сарын 28
III төсөл ба Эцэслэсэн хувилбар	2018 оны 7-р сарын 11

Хэнд зориулсан:

Давуу эрхтэй зээлдүүлэгчдийн групп

Багийн гишүүд:

Жиованни Ди Франчи	Төслийн менежер, багийн ахлагч - Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн
Роберт Сноу	Ахлах хянагч - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, уул уурхайн мэргэжилтэн
Дана Стренгт	Байгаль орчин/Гидрологийн мэргэжилтэн
Эми Сэкстон, Анжела Рийман	Нийгмийн /Орон нутгийн харилцааны мэргэжилтнүүд
Ровена Смац, Жоанна Трийвик	Биологийн олон янз байдлын мэргэжилтнүүд

RINA Consulting S.p.A.

Società soggetta a direzione e coordinamento amministrativo e finanziario del socio unico RINA S.p.A.

Via San Nazaro, 19 - 16145 Genova

Tel. +39 010 3628148 - Fax +39 010 31961 - www.rina.org - rinaconsulting@rina.org

C.F. / P. IVA / R.I. Genova N. 03476550102 - Cap. Soc. € 20.000.000,00 i.v.

All rights, including translation, reserved. No part of this document may be disclosed to any third party, for purposes other than the original, without written consent of RINA Consulting S.p.A.

Зохиогчийн бүх эрх (орчуулгад ч мөн хамаарна) Рина Консалтинг компанид хадгалагдана. Энэхүү баримт бичгийн аль ч хэсгийг Рина Консалтинг компаниас бичгээр зөвшөөрөл авалгүйгээр анхны зорилгоос өөр аливаа зорилгоор гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

Рина Консалтинг компани
“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Товчилсон үгсийн тайлал

АЯХХМТ	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө
АЧХШТ	Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө
АХАГУБ	Агаарын хөлгийн аврах, гал унтраах баг
БОНЭМАА	Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
БОЯБУАТ	Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
БОЯБҮМХ	Биологийн олон янз байдлын үнэлгээ, хяналт шинжилгээний хөтөлбөр
БОЯБМТ	Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө
БТБМТ	Бизнесийн тогтвортой байдлын менежментийн төлөвлөгөө
ХДХЗО	Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсман
БОЯБҮХШ	Биологийн олон янз байдлын үндсэн хяналт шинжилгээ
НЭХТМ	Ноцтой эрсдлийн хяналтын талбайн магадлагаа
НЭХМ	Ноцтой эрсдлийн хяналтын магадлагаа
ХХБХШС	Хүлэмжийн хийн байнгын хяналт шинжилгээний систем
ГЕЗ	Гүйцэтгэх ерөнхий захирал
СӨ	Соёлын өв
СӨМТ	Соёлын өвийн менежментийн Төлөвлөгөө
СӨМС	Соёлын өвийн менежментийн систем
ДТС	Дулааны төв станц
ИХТ	Иргэдийн хөгжлийн төв
ТШХО	Том ширхэгт хүдрийн овоолго
НЭМ	Ноцтой эрсдлийн менежмент
ОНТО	Орон нутаг, талуудын оролцоо
ОНТОХС	Орон нутаг, талуудын оролцоог хянах систем
ОНХНХ	Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлага
ОНХНХМС	Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын менежментийн систем
ХДС	Хөгжлийг дэмжих сан
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЦДЧ	Цахилгаан дамжуулах чанар
ЭЗА	Экспортын зээлийн агентлагууд
КЭХА	Канадын экспортын хөгжлийн агентлаг
ЭСДК	Экспортын санхүү, даатгалын корпораци
МТ	Малчдын төлөөлөл
ОБУББААХТ	Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээний төлөвлөгөө
ХХ	Хөдөлмөрийн харилцаа
ОБТ	Онцгой байдлын төлөвлөгөө
ОБУААХЖ	Онцгой байдлын үед авах арга хэмжээний журам
ОББ	Онцгой байдлын баг
БОНУАТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
ЭҮҮХШТ	Экосистемийн үйлчилгээний үнэлгээ, хяналт шинжилгээний төлөвлөгөө
ОУБОЯБХ	Олон улсын биологийн олон янз байдлын хамгаалал
ГХ	Гүний хоолой
ХХЯ	Хүлэмжийн хийн ялгаралт
СОУТТ	Салбарын олон улсын тэргүүн туршлага

Рина Консалтинг компани
“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

ХН	Хүний нөөц
ЭМААБО	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин
ЭМААБООНМС	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутгийн менежментийн систем
ЭМААБООН	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг
ЭМААБООН	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг
БОНХЗ	Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх
ХШЗ	Хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллага
ХАШИХМТ	Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө
ДБХТХТ	Дахин боловсруулах хаягдал түр хадгалах төв
ККБ	Клохн Криппен Бергер
ГҮҮ	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд
ЗБОЯБҮАТ	Зээлдүүлэгчдийн шаардсан Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
ГХХНСМТ	Газар хөндөлтийн хяналт ба нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө
ГХЗ	Газар хөндөх зөвшөөрөл
АХМТ	Ажиллах хүчний менежментийн төлөвлөгөө
ХЧАОГ	Хөдөлмөрийн чадвар алдсан осол гэмтэл
ХЧАОГДХ	ХЧАОГ-ийн давтамжийн хэмжээ
ГАМТ	Газар ашиглалтын менежментийн төлөвлөгөө
ШУА	Шинжлэх ухааны академи
ОТШБ	Олон талт шинжээчдийн баг
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ОТБГА	Олон талын баталгаа гаргагч агентлаг
УЛТ	Уурхайн лицензийн талбай
ӨМ	Өөрчлөлтийн менежмент
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ЭХМТ	Эрдэс хаягдлын менежментийн төлөвлөгөө
ХҮЧ-гүй	Хүчиллэг урсац үүсгэх чадвартай
ӨМ	Өөрчлөлтийн мэдэгдэл
НУУТ	Нутгийн ургамал үржүүлгийн төв
ЦЭН	Цэвэр эерэг нөлөөлөл
ДХМТ	Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө
ОТ	Оюу толгой
ОТ-ГС	Оюу толгой - Гашуунсүхайд
ОТ-ХБ	Оюу толгой - Ханбогд
ХҮЧ-тай	Хүчиллэг урсац үүсгэх чадвартай
БОХОХШ	Байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээ
БАСМТ	Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөө
БМТ	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө
ГШ	Гүйцэтгэлийн шаардлага
ГС	Гүйцэтгэлийн стандарт
НШҮАТ	Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө
РТ	Рио Тинто
РТБШ	Рио Тинто Бизнес Шийдэл

Рина Консалтинг компани
“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

СЧБ	Стандарт чартеред банк
ОТХАТ	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө
ОЗЗТА	Орон зайн загварчлал, тайлагналын арга
АХХ	Ажлын хамрах хүрээ
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
УХБНХ	Ууссан хатуу бодисын нийт хэмжээ
ТМТ	Тээврийн менежментийн төлөвлөгөө
ГТЗ	Гурван талт зөвлөл
т/хон	тонн/хоног
ХХБ	Хаягдал хадгалах байгууламж
ГУ	Гүний уурхай
АНУ ЭИБ	АНУ-ын экспорт импортын банк
ЧУП	Чичиргээт, утастай пьезометр
ЗАХН	Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг
ХХМТ	Хог хаягдлын менежментийн төв
УХШТ	Усны хяналт шинжилгээний төлөвлөгөө
ХЧО	Хаягдал чулуулгийн овоолго
УНМТ	Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

“Оюу толгой төсөл” нь (цаашид “Төсөл” буюу “ОТ төсөл” гэнэ) Өмнөговь аймгийн Ханбогд суманд¹ байрлах, дэлхийд томоохонд тооцогдох зэс-алтны уурхайн төсөл юм. Уг төсөл нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойш 80 км-т, Өмнийн говийн бүс нутагт байрладаг. Тус орд нь зэс, алт, мөнгө болон багахан хэмжээний молибден бүхий хэд хэдэн бүлэг ордоос бүрдэнэ. Уг төслийг Монгол Улсын Засгийн газрын бүрэн эзэмшлийн “Эрдэнэс Оюу толгой” (34 хувь) компани, Түркойз хилл ресурс (66 хувь) компаниудын хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж болох “Оюу толгой” ХХК (цаашид “Төслийн компани” буюу “ОТ” гэх) хэрэгжүүлж байна. Рио Тинто (РТ) нь Түркойз хилл ресурс компанийн гол хувьцаа эзэмшигч бөгөөд 2010 оноос хойш бүх хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн уг төслийг албан ёсоор удирдаж байна. Уг төсөл нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа зэс-алтны ил уурхай, түүнээс гарсан хүдрийг боловсруулах үйл ажиллагаа, зэс-алтны гүний уурхайн бүтээн байгуулалт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагаанаас бүрдэнэ.

2013 оны 9-р сараас эхлэн Итали Улсын Генуя хотод байрлах Д'Апполониа компани (2017 оны 6 дугаар сарын 5-наас хойш “Рина Консалтинг” болсон)² ОТ төслийг санхүүжүүлж буй Давуу эрхтэй зээлдүүлэгчдийн³ группийг төлөөлөх Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх (БОНХЗ)-өөр томилогдсон билээ.

БОНХЗ нь баримт бичигт тулгуурласан аудит хийхээс гадна Төслийн талбайд хуваарийн дагуу очиж шалгалт хийн, уг Төсөл хүлээсэн үүрэг амлалтаа Зээлдүүлэгчдийн холбогдох стандарт шаардлагын дагуу биелүүлж буй эсэхэд хяналт тавих үндсэн үүрэгтэй. Тодруулбал:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНУАТ-нд тодорхойлсон үүрэг хариуцлагын хэрэгжилт, биелэлтэд үнэлгээ хийх;
- ҮАМТ, БОНУАТ-ний үүрэг амлалттай холбоотой аливаа зөрчил, дутагдлыг илрүүлэх, илэрсэн тохиолдолд Салбарын олон улсын тэргүүн туршлага (СОУТТ) -д⁴ үндэслэн зөрчил, дутагдал арилгах санал зөвлөмж өгөх;
- БОНХЗ-ийн зүгээс 2017 оны 10-р сард гаргасан Баримт бичигт тулгуурласан тайлан⁵ болон 2017 оны 12-р сард хийгдсэн Усны хяналт үнэлгээний нарийвчилсан тайланд⁶ дурдсан тодорхой асуудал, зөрчил, ажиглагдсан зүйлсийн мөрөөр авсан арга хэмжээг шалгаж, хаах үүрэгтэй.

Энэхүү тайланд БОНХЗ-ийн 2018 оны 4-р сард хийсэн Баримт бичигт тулгуурлан хийсэн аудит, мөн 2018 оны 4-р сарын 16-26-ны өдрүүдэд ОТ уурхайн цогцолборын ажилтнуудтай хийсэн теле-хэлэлцүүлгийн үр

¹ Сум гэдэг нь Монгол Улсын засаг захиргааны хоёр дахь түвшний нэгж юм. Одоогийн байдлаар Монгол Улсад 300 орчим сум байна.

² 6-р сарын 5-нд Д'Апполониа компани болон Рина группийн бусад инженерингийн зөвлөх компаниуд нэгдэж, Рина Консалтинг компанийг үүсгэсэн. Тиймээс Рина Консалтинг нь Д'Апполониа (D'Appolonia), Центро Свилуддо Материали (Centro Sviluppo Materiali), Эпиф ИАРЭЙ Технологи (Edif ERA Technology), Жи.И.Ти (G.E.T), Логмарин Эдвайзорс (Logmarin Advisors), ӨүЭсТи Энэржи (OST Energy), Поарис (Polaris), СиЭс Сэмбэнэли Консалтинг (SC Sembenelli Consulting), Ситек (Seatech) зэрэг олон улсад нэр хүндтэй хэд хэдэн компаниудыг нэгтгэсэн инженерингийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний арвин их өв туршлагыг нэг дор цуглуулсан байгууллага юм.

³ Давуу эрхтэй Зээлдүүлэгчдийн группэд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ), Канадын экспортын хөгжлийн агентлаг (КЭХА), АНУ-ын экспорт, импортын банк (АНУ ЭИБ), Экспортын санхүү, даатгалын корпораци (ЭСДК), Олон талын баталгаа гаргагч агентлаг (ОТБГА), Стандарт чартеред банк (СЧБ), БиЭнПи Парибас зэрэг байгууллагууд багтдаг.

⁴ 2007 оны 4-р сард ОУСК-аас гаргасан БОЭМАА-ны удирдамжид Салбарын олон улсын тэргүүн туршлага (СОУТТ) гэдгийг “олон улсад ижил төстэй нөхцөлд, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй, туршлага, үр чадвар эзэмшсэн мэргэжилтнүүдэд зүй ёсоор тавигдах мэргэжлийн үр чадвар, хичээл зүтгэл, онц ухаан, алсыг харах чадвар...” хэмээн тодорхойлжээ.

⁵ Рина консалтинг, “Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн нийцлийн хяналт шинжилгээний тайлан – 2017 оны 10-р сар – Явцын тайлан”, баримт бичгийн дугаар 13-391-Н11, 2018 оны 3-р сар.

⁶ Рина консалтинг, “БОНХЗ-ийн тайлан: ОТ-н усны нарийвчилсан үнэлгээ – Лондонгийн үүлзалт: 2017 оны 12-р сарын 5-6”, Баримт бичгийн дугаар 13-391-Н12, 2018 оны 1-р сар.

дүнг дэлгэрэнгүй тусгасан. Аудитын үндсэн зорилго нь төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сүүлийн үеийн баримт мэдээлэлд шинжилгээ хийх, БОНХЗ уурхайн талбайд хамгийн сүүлд ажилласнаас хойш төслөөс мэдээлсэн аливаа зөрчил дутагдал, нөлөөллийг авч үзэх, улмаар Төслөөс хэрэгжүүлж буй нөлөөлөл бууруулах арга хэмжээ зохих шаардлагын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой.

Энэхүү тайланд Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө (ҮАМТ), Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) болон бусад холбогдох баримт бичигт тусгасан Төслийн үүрэг амлалттай холбоотой илэрсэн зөрчлийг арилгах талаар ямар арга хэмжээ авч байгаа тухай мэдээллийг тусгав.

Баримт бичгийн хяналтад үндэслэн хийсэн энэ удаагийн аудитын тайланд онцолсон гол зүйлсийг дор товч хураангуйлав.

Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо

Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо нь төслийг удирдан явуулах, Төслийн стандартууд, Монгол Улсын хууль, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл, 2009 оны 10-р сарын 6-нд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, ОУСК, ЕСБХБ-ны байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгмийн бодлого, стандарт шаардлагуудыг хангах цогц тогтолцоо юм. Уг менежментийн систем болон холбогдох Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) нь тасралтгүй шинэчлэн сайжруулахад чиглэсэн төлөвлөх, үйл ажиллагаа явуулах, тайлагнах, хяналт тавих зэрэг үе шатуудаас бүрдэнэ. Тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөнд төслийн үүрэг амлалт, гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд, хэрэгжилтийг хангах холбогдох баримт бичгүүдийг тодорхойлдог. Уг тогтолцооны бас нэг хэсэг нь Өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх процесс бөгөөд энэ тайлангийн холбогдох хэсгүүдэд дурдсан төслийн төлөвлөгөө, үүрэг амлалтад засвар өөрчлөлт оруулах явцыг уг процессын дагуу удирдан явуулдаг. Зээлдүүлэгчид эдгээрийн ихэнхийг хүлээн зөвшөөрсөн.

Ус, хаягдал усны менежмент

2014 оны 12-р сард ОТ болон Малчдын төлөөлөл (МТ) нь ОУСК-ийн Эрх зүйн хяналт, зөвлөгөө, омбудсмэний газар (“ЭЗХЗОГ”)–с чиглүүлэн явуулдаг уулзалтуудыг орон нутгийн оролцогч талуудыг оролцуулан тогтмол хэлэлцүүлэг байдлаар хийж, Ундай голын голдиролд хийх тохируулгыг эцэслэн шийдвэрлэхээр тохиролцсон. Оролцогч талуудад ОТ, Малчдын төлөөлөл, Ханбогд сумын захиргаа багтана. Эдгээр талууд хамтдаа Гурван талт зөвлөлийг бүрдүүлнэ. Гурван талт зөвлөл нь усны нөөцийг хадгалах, уурхайн лицензийн талбай дахь Ундай голын голдирол ширгэхээс хамгаалах зэрэг нөхцөлийг хангасан тохиолдолд Ундай голын голдиролд хэсэгчлэн тохируулга хийх, хамгаалах төслийг зөвшөөрсөн. Эдгээр нөхцөлийг ОТ харгалзан үзэж, шаардлагатай арга хэмжээг авч байгаа. Ундай голын голдиролд тохируулга хийх эцэслэсэн хувилбарын дагуу Өөрчлөлтийн хүсэлтийг 2017 оны 5-р сарын сүүлээр гаргасан бөгөөд Зээлдүүлэгчид 2017 оны 6-р сард энэ хүсэлтийг (Өөрчлөлтийн хүсэлт 2016-014) баталсан.

2017 оны 8-р сард Ундай гол үерлэсэн нь 25 жилд нэг тохиолдох үйл явдал юм. Энэхүү үер нь Ундай голын голдиролд хийсэн тохируулгыг шалгасан сорилт болсон. Энэ үерийн дараа Усны нарийвчилсан үнэлгээ хийгдэж, 2017 оны 12-р сард дууссан бөгөөд үнэлгээний үр дүнг *БОНХЗ-ийн тайлан: ОТ-н усны нарийвчилсан үнэлгээ (2017 оны 12-р сар)* баримт бичигт танилцуулсан. 2017 оны 4-р улиралд хийгдсэн усны нарийвчилсан үнэлгээний гол үр дүнг энэхүү тайланд тоймлон дүгнэсэн. ОУСК-ийн Эрх зүйн хяналт, зөвлөгөө, омбудсмэний газар (“ЭЗХЗОГ”)–н хяналт удирдлага дор явагдсан маргаан шийдвэрлэх хүчин чармайлтын үр дүнгийн талаар энэхүү Усны нарийвчилсан үнэлгээнд мөн тусгасан. Энэ хүчин чармайлтын үр дүнг *Олон салбарыг хамарсан судлаачдын баг ба Бие даасан шинжээчдийн зөвлөлийн Шинжээчийн тайлангийн дүгнэлтийн талаарх хамтарсан мэдэгдэл (2016 оны 12-р сар)* баримт бичигт танилцуулсан.

2017 онд ОТ-н гүний хоолойд хяналтын цооногуудыг (гурван газарт хяналт шинжилгээний 9 цэг) нэмэлтээр гаргасан. Усны мониторингийн төлөвлөгөө (УМТ) -нд тусгасны дагуу хяналтын нэмэлт цооног өрөмдөх, суурилуулах ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. 2018 онд 20 цооногийг битүүмжилнэ.

2016 онд ОТ уурхай 1 тонн хүдэр боловсруулахад Гүний хоолойгоос дунджаар 400 литр түүхий ус буюу давсархаг ус хэрэглэсэн нь 1 тонн хүдэр боловсруулахад 547 литр ус зарцуулна хэмээсэн зорилтоосоо бага байгаа бөгөөд 1 тонн хүдэр боловсруулахад 1,220 литр ус ашигладаг дэлхийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад үнэмлэхүй бага хэмжээ юм. 2017 онд нийт дахин боловсруулан ашигласан усны хэмжээ 86.2%-д хүрсэн нь 2016 онд мөн 86.2% байсантай адил байна. Дахин боловсруулан ашиглах усны хэмжээ 80% байхаар заасан Гүйцэтгэлийн гол үзүүлэлтээс дээрх хоёр оны үзүүлэлт хоёулаа сайн байгаа юм.

Эрдсийн хаягдлын менежмент

Ил уурхай, Хаягдал чулуулгийн овоолго (ХЧО), Хаягдал хадгалах байгууламж (ХХБ)-аас гарах эрдсийн хаягдлын менежментийг Төслийн стратегийн дагуу хэрэгжүүлж байна. Овоолсон хаягдал чулуулгийг Хүчиллэг урсац үүсгэх чадвартай (ХУҮЧ-тай) материал, Хүчиллэг урсац үүсгэх чадваргүй (ХУҮЧ-гүй) материал гэж ангилан ялгах, геотехникийн Expit програмаар Эрдсийн хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ хийдэг. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил дахин эхэлсэнтэй холбоотойгоор хаягдал чулуулгийг шинээр байгуулсан Хүчиллэг урсац үүсгэх чадвар (ХУҮЧ)-тай материалд зориулсан хаягдал чулуулгийн нэгдсэн шинэ овоолго руу зөөвөрлөж байна. Өмнөд овоолгын зах хэсэгт ХЧО-ыг ургамалжуулах туршилтын төслийн хүрээнд ХҮЧ-гүй болон ХҮЧ-тай эрдсийн хаягдлын хучилт хийх ажлыг гүйцэтгэсэн ба цаашид шимт хөрс, ургамлан давхаргыг байгуулах ажлуудыг тус туршилтын талбайд хийх юм.

Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг ХХБ руу шахан зайлуулж, эргэлтийн усыг ялгаж авдаг. Одоогоор ХХБ-ийн 1-р бассейныг ашиглаж байна. 2018 онд үргэлжлэн хийгдэх хаягдал хуримтлуулахад зориулсан чулуун далангийн барилгын ажил 32 хувийн гүйцэтгэлтэй байна. ХХБ дээр эргүүлэн татах усны менежментийг шахуургын станц ашиглан гүйцэтгэж байгаа боловч 2018 оны 3-р сарын 17-ноос 4-р сарын 6-ны хугацаанд далангийн түвшин нь дизайны шаардлагад хүрэхгүй байсан. Буцаан татах цөөрмийн ойролцоо барилгын ажил ид өрнөж байгаа тул далангийн түвшинг өндөрсгөнө. ХХБ-ийн зүүн хойд хэсгийн улнаас гарч буй шүүрэл нь байгууламжийн төлөвлөгөө, тооцооны дагуу байгаа бөгөөд хяналт шинжилгээ тогтмол хийж байгаа. 2017 оны 12-р сард ХХБ-ийн өмнөд хэсгийн улнаас шүүрэл гарч байгаа нь ажиглагдсан бөгөөд ХХБ-ийн инженерийн зураг төслийн байгууллага шүүрэл цуглуулах, хянах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байна.

Эрдсийн бус хаягдлын менежмент

Аудитын явцад цуглуулсан мэдээллээс үзэхэд, үйлдвэрлэлийн явцад гаргаж байгаа бүх хог хаягдлын менежментийг Төсөл өөрийн хүчин чадлаар зохицуулсан хэвээр байна. Дахин боловсруулах хог хаягдал түр хадгалах төвийг (ДБХТХТ) ашиглалтаас гаргасан ба 2017 оны 12-р сард Дэд бүтцийн хэлтсээс Байгаль орчны хэлтэст албан ёсоор хүлээлгэн өгсөн. Хог хаягдлын менежментийн төв (ХМТ) -ийг үндсэн гэрээт компани хариуцан ажиллуулж, хог хаягдал дахин боловсруулагч бусад компаниудыг туслан гүйцэтгэгчээр ажиллуулан, хог хаягдлыг техникийн тос, гал тогооны хаягдал тос, хаягдал төмөр, хаягдал аккумулятор, хаягдал цаас, кабель зэргээр ялган ангилж байна. Ерөнхий хог хаягдлыг хадгалах нэгдүгээр хэсгийг үргэлжлүүлэн ашигласаар байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт багтаамжийн 61 хувийг ашиглаад байна. Нэмэлт 2 ба 3 дугаар хэсгийн инженерийн зураг төсөл хийгдэж дууссан бөгөөд барилгын ажлыг 2018 оны 4-р улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн.

Агаарын чанар

Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламжид их хэмжээний тоос үүсэж байдаг. Уг тоосыг бууруулах зорилгоор хөөсөөр тоос дарах систем (гадаргуун идэвхит бодисын систем) суурилуулсан. Ингэснээр ТШХО байгууламжийн дотор агаар дах нийт тоосны нягтрал (TSP) мэдэгдэхүйц багассан байна. Гэхдээ орчны агаар дахь бодисын хяналт шинжилгээний мэдээнээс үзэхэд төслийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн хэвээр байна. Өнгөрсөн жил энэ чиглэлээр томоохон сайжруулалтуудыг хийсэн. Үүнд туузан дамжуургын төгсгөл хэсэгт хаалт суурилуулах, нунтаглагч тээрмийн (ХӨН) буцах эргэлт дээрх материал буцалтыг багасгах зорилгоор шүүр тавих, цэвэрлэгээ хийх үеийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс дамжуургын дор хамгаалалтын тор суурилуулах зэрэг ажлууд багтана.

“ТШХО-ын байгууламжид салхинаас хамгаалах торон хаалт суурилуулах” төсөл хэрэгжиж байна. Энэ төсөл нь ТШХО-ын байгууламжийн доторх нарийн ширхэгт тооцонцорыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ торон хаалт нь өндөр нягтралтай полиэтиленээр (HDPE) хийгдсэн, хэт ягаан туяаны хамгаалалттай, галд тэсвэртэй бөгөөд аж үйлдвэрийн төрөл бүрийн салбарт тоосжилтоос сэргийлэхэд өргөн ашиглагддаг. Компанийн дотоод журмын дагуу гаргасан Капитал санхүүжилтийн хүсэлт батлагдсан. Торон хаалтыг суурилуулах ажлыг 2018 оны 2-р улиралд эхлэн, мөн оны 3 / 4-р улиралд дуусгахаар төлөвлөсөн. Ингэж салхинаас хамгаалах торон хаалт суурилуулснаар салхины хурд буурч, ТШХО байгууламжийн ойр хавийн тоосжилтыг их хэмжээгээр бууруулах юм. Дараа дараагийн аудитын тайланд хэрэгжилтийг баримтжуулах болно.

Түүнчлэн агаарын чанарын хяналт шинжилгээний шинэ сүлжээг байгуулж, ашиглалтад оруулсан. Уг системийн үйл ажиллагаа одоо жигдэрсэн ба байнгын хяналт шинжилгээнээс авсан мэдээллийг дараа дараагийн БОНХЗ-ийн тайланд оруулж байна..

ДТС-аас гарч буй утааны чанар Төслийн стандартад хүрэхгүй байгаа асуудал удаа дараа тавигдсаар ирсэн. Станцын утаанд хяналт шинжилгээ хийсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр утаанаас дээж авахад хэрэглэж байгаа аргачлалд хэд хэдэн дутагдалтай тал байгааг илрүүлсэн. 2018 онд Дулааны төв станцын хүчин чадлыг 130 МВт болгох 2 дахь шатны өргөтгөлийн ажлын хүрээнд Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС)-ийг үндсэн янданд суурилуулна. Энэ нь АЧХШТ-ний байнгын хяналт шинжилгээ хийх шаардлагад нийцсэн ажил юм. Бүх бойлеруудад бүрэн засвар үйлчилгээ хийсэн, нийт 1,500 гаруй уутат шүүлтүүр сольсон зэрэг бусад сайжруулалтын ажлууд мөн ДТС-д хийгдсэн.

ОТ хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) хэмжээг бүртгэдэг бөгөөд 2017 онд нийт 1,572,355 CO₂ (экв) бүртгэгдсэн. Энэ нь 2016 онд бүртгэгдсэн 1,429,626 тонн CO₂-той харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Хүлэмжийн хийн хэмжээ өссөн нь гүний уурхайн төслийн 2-р шатны бүтээн байгуулалттай холбоотойгоор эрчим хүчний худалдан авалт өссөнтэй холбоотой. 2017 онд ялгаруулсан нүүрсхүчлийн хийн 80% нь 2-р хүрээнд хамаарах эх үүсвэрээс эрчим хүч худалдан авсантай холбоотойгоор 1,274,681 CO₂ (экв) бүртгэгдсэн. 1-р хүрээнд хамаарах шүүд эх үүсвэрээс ялгарсан нүүрсхүчлийн хийн хэмжээ нь 297,673 CO₂ (экв) байсан бол 3-р хүрээнд хамаарах шүүд бус эх үүсвэрээс үүссэн нүүрсхүчлийн хэмжээ маш бага байгаа юм.

Хөндлөнгийн байгууллагаас Оюу толгойн хүлэмжийн хийн ялгаруулалтад хийсэн үнэлгээний тайланг 2016 онд гаргасан. Уг тайланд ХХЯ-ын мэдээллийг Рио Тинтогийн Хүлэмжийн хий, эрчим хүчний хэрэглээний ажлын журналд заасан шаардлагын дагуу тодорхойлсон. Хүлэмжийн хийг 2016 онд гаргасан Рио Тинтогийн Хүлэмжийн хий, эрчим хүчний хэрэглээний ажлын журналд заасан аргачлалаар бүртгэдэг. Рио Тинтогийн хүлэмжийн хийн бүртгэл нь Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн зөвлөл/Дэлхийн нөөцийн институтын Хүлэмжийн хийн протоколд тусгасан тодорхойлолтуудад үндэслэсэн байдаг.

Онцгой байдлын үеийн бэлэн байдал, харуу арга хэмжээ

Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй (ОБҮББХАХТ) уялдуулан Төслийн өндөр болон ноцтой эрсдэл бүхий ажлын талбайнууд/хэлтсүүдэд гарч болзошгүй ослыг удирдах онцгой байдлын хариу арга хэмжээний журмуудыг (ОБХАХЖ) боловсруулсан. Уурхайд бүхэлд нь болон тухайн ажлын талбай/хэлтэст учирч болзошгүй эрсдэлд чиглэсэн онцгой байдлын хариу арга хэмжээний 15 журам боловсруулагдсан бөгөөд 2018 онд Ил уурхайд онцгой байдлын хариу арга хэмжээний журмыг шинэчлэн боловсруулсан.

Онцгой байдлын нөлөөлөлд хамрагдах талбайг нарийвчлан тодорхойлох ажил дуусаагүй байгаатай холбогдуулан ХХБ-ийн ОБХАХЖ-ыг хараахан шинэчлээгүй байна. Үүнтэй холбоотойгоор нутгийн иргэдэд ХХБ, онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаар танилцуулах ажил ч хүлээгдэж байна. ХХБ-ийн орон нутаг, оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний шинэчлэлт, хэрэгжилтийг одоогийн ХХБ-ийн ОБХАХЖ-ын дагуу үргэлжлүүлэн явуулах шаардлагатай болж байна.

Гүний уурхайн онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2018 оны 1-р сард шинэчилж, Уул уурхайн яаманд хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөнд оны сүүлийн хагаст хийгдсэн гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотой гол ажлуудыг тусгасан.

Тээврийн менежмент

Тээврийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд танилцуулах сургалт, орон нутаг, байгаль орчны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж байгаагаас гадна зэсийн баяжмал тээвэрлэж байгаа операторуудын алжаал ядаргаанд хяналт тавих, удирдах хөтөлбөрийг нэвтрүүлсэн. ОТ-Гашуунсүхайтын авто замаар хийгдэж буй баяжмал тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Экспортын тээвэрлэлтийн баг нь 2018 онд Чойрын төмөр замын терминалаар 20 мянган тонн зэсийн баяжмал тээвэрлэн экспортлохоор төлөвлөж байгаа бөгөөд 2018 оны 2-р сард 9 цувааг хүргэсэн. Тээврийн менежментийн төлөвлөгөөнд ОТ - Чойр чиглэлийн замыг тусгаж, аюулгүй байдал, хяналт шалгалтын удирдлага хяналтын арга хэмжээг хэрэгжүүлж, баталгаажуулах шаардлагатай байна.

Экологийн менежмент, биологийн олон янз байдал

Авто замын нөлөөллийг бууруулах стратегитай холбоотой зөрчлийн хувьд сөрөг нөлөөллийг бууруулах үр дүнтэй стратеги боловсруулах зорилгоор нэмэлт мэдээлэл цуглуулах, тайлбараар хангах зөвлөмж өгч, үг зөрчлийг хаасан. Ховор ургамалтай холбоотой (Грубовын хөөндий) III түвшний зөрчил шинээр нэмэгдсэн.

Цахилгаан дамжуулах шугамтай холбоотой нөлөөллийг удирдан зохицуулах

Тусгаарлалт ба шувуу тогонд цохиулах эрсдэлд тавих хяналт

Өмнөх аудитаас хойш Гүний хоолойн цооногийн талбайд шувуу тогонд цохиулснаас шалтгаалсан хорогдол харьцангуй цөөрсөн байна: Гүний хоолойн цахилгааны шугамыг таван шувуу (дөрвөн хэрээ, нэг алагтуу) мөргөсөн байснаас дөрөв нь тусгаарлагчгүй шонг мөргөсөн бол нэг нь тусгаарлагчтай шонг мөргөжээ. Ийм шалтгаанаар гарсан шувууны хорогдол 2017 онд 13, 2016 онд 34 байсантай харьцуулахад хорогдол буурсан байна. ОТ нь Гүний хоолойн цооногийн талбай дахь бага эрсдэлтэй 11 шонд тусгаарлалт хийгээгүй. Эдгээр шон болон тусгаарлалт суурилүүлсан бусад 119 шонгуудад үргэлжлүүлэн мониторинг хийж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний (тусгаарлалт болон шувуу үргээгч) үр дүнд үнэлгээ хийнэ.

Эн тэргүүнд хамгаалах шаардлагатай шувуудын төрөл зүйл тогонд цохиулах эрсдэлд тавих хяналт

Өмнөх аудитаас хойш ОТ-н 220 кВ-ын цахилгааны шугамыг 22 шувуу (17 ногтруу, 3 нөмрөг тас, 1 ууль, 1 гангар хүн) мөргөж эрсдэжээ. Цахилгаанд цохиулах эрдлээс шалтгаалан жороо тоодог эрсдээгүй бөгөөд эн тэргүүнд хамгаалах шаардлагатай шувуудын бусад төрөл ч эрсдээгүй байна.

Хонин тоодог болон жороо тоодогт үзүүлэх нөлөөллийг бууруулах хүчин чармайлтынхаа хүрээнд ОТ нь жороо тоодог судлах олон жилийн судалгааны төсөл хэрэгжүүлж буй орон нутгийн ТББ-тай хамтран ажиллаж байна.

Оролцогч талуудтай хамтран ажиллах

Энэхүү аудитын явцад БОНХЗ нь а) цаашдын хамтын ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө болон б) өмнөх хамтын ажиллагааны бүртгэл тэмдэглэл зэрэг баримт бичгүүдтэй танилцлаа. Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний (ОТХАТ) хэрэгжилтийн тайлангийн шинэчилсэн хувилбарыг БОНХЗ-д танилцуулсан бөгөөд 2017 онд хийгдсэн үүлзалтуудыг тоймлон, дүйцүүлэн хамгаалах төслийн төрлөөр нь ангилан тоймлон дүгнэсэн байв. Өмнөх аудитын үеэр гаргасан хүсэлтийн дагуу оролцогч талуудын 2018 онд хийгдэх үүлзалт/хамтын ажиллагааны хуваарийг дүйцүүлэн хамгааллын 4 үндсэн төслийн төрлөөр ангилан БОНХЗ-д танилцуулсан. Өмнө нь БОНХЗ-н зүгээс зохих түвшний нарийвчилсан төлөвлөгөө байхгүй байгааг анхааруулсны мөрөөр төмөр замын торон хашааг буулгах төсөлтэй холбоотой 2018 оны хамтын ажиллагааны хуваарийг БОНХЗ-д танилцуулсан.

Экосистемийн үйлчилгээ

Аудитын үед Экосистемийн үйлчилгээний хяналт үнэлгээний төлөвлөгөө (ЭҮХҮТ)-ний хураангуй тайлантай (2017) танилцсан. Ерөнхийдөө, БОНХЗ-д мэдээлснээр, экосистемийн үйлчилгээнд өөрчлөлт ороогүй. Зарим тохиолдолд экосистемийн зарим чухал үйлчилгээнд бага зэрэг өөрчлөлт орсон ч, аливаа томоохон хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

2017 онд ОТ босго үзүүлэлттэй бүх шалгуур үзүүлэлтийн хяналтыг хэрэгжүүлсэн хэмээн БОНХЗ-д мэдээлсэн. Гэсэн хэдий ч олон тооны шалгуур үзүүлэлт, тэр дундаа Засгийн газраас тодорхойлсон болон бэлчээрийн хэмжүүрийг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийн хувьд ч босго үзүүлэлт тодорхойгүй байсан бөгөөд эдгээрийг тодорхойлж гүйцсэн. Биомасс, цэвэр ус, усны зохицуулалтын хэд хэдэн үзүүлэлтийн хувьд одоо ч босго үзүүлэлт тодорхойгүй байна. Голын амьдрах орчныг нөхөн сэргээхэд тэнд тарьсан ургамлын амьдрах чадварын хувь хэмжээг харгалзан үзэх шаардлагатай байна.

ОТ нь Тогтвортой ноолуур төслийн амжилтыг баталгаажуулахын тулд 35 000 га бэлчээрийн газрын чанарыг 10%-р сайжруулах зорилт тавьсан. Гэсэн хэдий ч ямааны тоо толгойг хэт өсгөхийг хязгаарласан зохицуулалт байхгүйн улмаас энэ зорилтыг хэрэгжүүлэхэд саад учирч болзошгүй юм. "Нөхөн сэргээсэн бэлчээрийн чанар"-н талаарх тайлан эцэслэн дуусаагүй байсан тул ЭҮХҮТ-д ороогүй болно. Зарим газар бэлчээрийн даац хэд дахин хэтэрсэн (улаан босго үзүүлэлт) байна.

ОТ үүнийг ган болсонтой холбож тайлбарласан бөгөөд өвөл малчдад туслах зорилгоор өвс тэжээл өгч байсныг дурьдсан. Гэхдээ Ханбогд сумын бэлчээрийн 1/5 орчим нь даац хэтэрсэн буюу улаан босгоос давсан бөгөөд 2010 оноос хойш сумын нийт малын тоо толгой 76% -р өссөн (ямааны тоо толгой 2010 оноос хойш бараг хоёр дахин нэмэгдсэн) зэрэг нь нэн ялангуяа ган гачгаас шалтгаалан өвс ургамал тарчиг байгаа үед бэлчээрийн дарамтыг улам нэмэгдүүлж байгаа санаа зовох ёстой асуудал мөн билээ. Энэ нь малын тоо толгойг хязгаарлах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатайг нотлон харуулж байгаа бөгөөд өмнөх аудитуудын үед ч БОНХЗ болон Зээлдүүлэгчдийн зүгээс энэ зөвлөмжийг өгсөөр байгаа юм. Малын тоо толгойн хувьд ямар ч босго үзүүлэлт байхгүй байгаа бөгөөд мал сүргийн өсөлтийг жилд 15% хэмээн тооцооноос өөр ямар ч арга хэмжээ аваагүй байна.

Ховор ургамлын төрөл зүйлийг хамгаалах

Өмнөх аудитаар эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйлийн хувьд шаардлагатай үр дүнд хүрэх баталгааны асуудлыг анхаарах шаардлагатайг тэмдэглэсэн. Төлөвлөгдсөн газар хөндөлтийн нөлөөлөлд өртсөн эн тэргүүнд хамгаалах шаардлагатай бүх төрөл зүйлийн хувьд тархалт, нөхөн сэргээлтийн найдвартай, тогтсон арга барил байхгүй байна.

“Грубовын хөөндий” ховор ургамлын зүйлд учирч буй эрсдэл нь төлөвлөгдсөн газар хөндөлттэй холбоотойгоор ургамлын төрөл зүйл аюулд орж байгаагийн жишээ юм. Анхаарах шаардлагатай асуудлуудыг дурдвал, уурхайн лицензийн талбайд уг ургамлын тархалт, амьдрах орчны шаардлагын талаарх ойлголт хангалтгүй, тархалтын арга барилыг боловсруулах үйл явц ахиц муутай, уурхайн лицензийн талбайд энэ төрөл зүйл байнга хөндөгдөж байгаатай холбоотой хуримтлагдсан нөлөөллийг бууруулах талаар авч буй арга хэмжээ хангалтгүй, амжилттай шилжүүлэн суулгасан болон тархан ургасан баримт нотолгоо байхгүй зэргийг нэрлэж болно. ОТ уурхай, кемп, дэд бүтцийн барилга байгууламжуудтай холбоотойгоор уурхайн лицензийн талбай дахь энэ төрөл зүйлийн тархалт нь сөрөг

нөлөөлөлд хэдийнэ өртсөн түл Грубовын хөөндийн ховор ургамлын зүйлд учрах хуримтлагдсан нөлөөлөлд анхаарах шаардлагатай. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд ОТ эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйл, тэр дундаа Грубовын хөөндийг хамгаалах зорилтын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх дараах зургаан арга хэмжээг (буюу төсөл) тодорхойлон, ахиц дэвшилд хүрээд байна: а) УЛТ болон уурхайн оролцоох газруудад эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйлийн тархалтыг судалснаар БОННУ-ний тархалтын суурь үзүүлэлттэй харьцуулахад тархац, популяцийн хэмжээг нэмэгдүүлэх; (b) амьдрах орчны шаардлагыг судлах; (c) Грубовын хөөндийн дэд бүтцийн байршлууд дахь тархалт; (d) Грубовын хөөндийн ховордсон төлөв байдалд дахин үнэлгээ хийхэд Монгол Улсын Их Сургуультай хамтран ажиллана - үнэлгээ 2019 онд эхлэх ба энэ зүйлийн тархалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ОТ нь дараах чиглэлээр ойлголтоо илүү сайжруулах шаардлагатай: (a) Грубовын хөөндийн ургамлын амьдралын мөчлөг, цэцэглэх, үрээ боловсруулах үе гэх мэт; (b) сүүлийн үеийн тархалтын зураглалын дагуух хамгааллын нөхцөл байдал; (c) эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын урьд өмнө хийгдсэн сорилууд; (d) эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын тархалтын шинэ сорил; (e) шилжүүлэн суулгасан Грубовын хөөндийн ургах чадвар - ялангуяа уг ургамлыг 4-р босоо ам орчмоос Нутгийн ургамал үржүүлгийн төв (НУУТ) рүү шилжүүлэн суулгасантай холбоотойгоор; (f) нутгийн популяци - үүнтэй холбоотойгоор ОТ сайт болон сайтаас бусад газрууд дахь популяцийн ач холбогдлыг илүү сайн ойлгох.

Эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйлд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх

Өмнөх аудитаас хойш ГХЗ-ийн журмын дагуу шинээр 200 га газар хөндөх зөвшөөрөл олгожээ. Хэдийгээр ОТ 4-р босоо амны эргэн тойронд Грубовын хөөндийн популяцид сөрөг нөлөөлөл учруулахаас зайлсхийх хүчин чармайлт гаргаж байгаа (Газар хөндөлтийн төлөвлөгөөний бүртгэл хөтлөх, дэд бүтцийн бусад боломжит талбайнуудыг судлах г.м) боловч сүүлийн үед байгуулж буй дэд бүтцийн байршил нь ихээхэн хэмжээний (2800 ширхэг) Грубовын хөөндийд нөлөөлж, тэдгээрийг НУУТ рүү шилжүүлэн суулгасан байна.

Грубовын хөөндийтэй холбоотойгоор БОНХЗ-ийн өгсөн өмнөх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар ОТ дорвитой ахиц дэвшил гаргасан байна. Үүнд: (a) өргөн хүрээтэй хээрийн судалгаа хийх замаар бүс нутаг дахь энэ зүйлийн тархацын хүрээ, ховор ургамлын зүйлийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлэх; (b) энэ зүйлийн ховордсон байдалд дахин үнэлгээ хийхэд Монгол Улсын Их Сургуультай хамтран ажиллах, шуурхай хянах аргаар тархалтыг бүртгэх (c) дэд бүтэц байгуулах боломжтой бусад байршлуудыг судлан тодорхойлох замаар Грубовын хөөндийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зайлсхийх зэргийг нэрлэж болно.

Гэсэн хэдий ч БОНХЗ нь эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйлд (ялангуяа Грубовын хөөндий) үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой III түвшний зөрчлийг⁷ шинээр бүртгэсэн.

⁷ БОНХЗ-ийн зүгээс Грубовын хөөндийд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, үржүүлэхтэй холбоотой санаа зовниж буй асуудал болон III түвшний зөрчилтэй холбоотой асуудлаар ОТ-той ярилцсаны дараа ОТ дараах үндэслэлээр энэ зөрчлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан. Барилга бүтээн байгуулалтын шатанд ховор ургамалд учрах нөлөөллийг БОННУ-нд тодорхойлон, үнэлгээ хийсэн бөгөөд цэвэр эерэг нөлөөллийг төслийн барилгын үе шатанд бий болгоно гэсэн үүрэг амлалт аваагүй. ОТ-н холбогдох журмуудыг мөрдөн хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид ч мөрдөн хэрэгжүүлж, Грубовын хөөндийд (бусад ховор ургамлын төрөл зүйлүүдэд) учрах сөрөг нөлөөллийг багасна. Грубовын хөөндий зэрэг ховор ургамалд учрах нөлөөллийг бууруулахын тулд Газар хөндөлтийн хяналт, Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0005), Ховор ургамал хамгаалах журам (ОТ-10-Е14-PRC-007) зэрэгт шат дараалсан арга хэмжээ, үйл явцыг тусгасан. Эдгээр төлөвлөгөө, журамд заасан бүх шаардлагыг ОТ-н бүтээн байгуулалт, ашиглалтын үйл ажиллагаанд байнга дагаж мөрддөг. Ховор ургамал хамгаалах журамд заасны дагуу ирээдүйд хийгдэх нөхөн сэргээлтэнд шаардагдах ургамлуудыг үржүүлэх хувилбарт аргыг боловсруулах зорилгоор судалгаа шинжилгээ хийх шаардлагатай ба Грубовын хөөндий болон бусад хоёр төрлийн ховор ургамал дээр энэ судалгааг хийхээр төлөвлөж байна.

Сүүлийн аудитаас хойш сөрөг нөлөөлөлд өртсөн 2800 ширхэг ургамлын хувьд (УЛТ дахь зүйлийн 20-иос дээш хувь гэж тооцсон) энэ төрөл зүйлийг амжилттай шилжүүлэн суулгаж, нөхөн сэргээж, үржүүлнэ гэсэн баримт нотолгоо байхгүй тохиолдолд зээлдүүлэгчдийн шаардлагад (PS6 ба PR6) нийцсэн цэвэр эерэг нөлөөлөл бий болгох зорилгыг хэрэгжүүлэх хангалттай баталгаа байхгүй байна.

ОТ-н Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө нь Зээлдүүлэгчийн холбогдох стандартууд, тэр дундаа PS6 болон PR6-г мөрдлөг болгох ёстой. PS6 болон PR6-ийн 14 ба 17-р зүйлд, байгалийн чухал ач холбогдолтой амьдрах орчин, эсвэл эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн төрөл зүйл бүхий газар нутагт томоохон хэмжээний хөндөлт хийхээс өмнө цэвэр эерэг нөлөөлөл бий болгоно гэсэн баттай нотолгоо болохуйц жишээ, нотолгоог бий болгосон байх шаардлагатай гэж заасан. Уул уурхайн нөхөн сэргээлт хийсэн ландшафтад ховор ургамлын төрөл зүйлийг шилжүүлэн суулгах, нөхөн сэргээх, тархаах хүчин чармайлт ихэвчлэн талаар болдог.

Сүүлийн үеийн сөрөг нөлөөллийн улмаас уурхайн талбай дахь ховор ургамлын зүйл цөөрсөн бөгөөд нөхөн сэргээх замаар эерэг нөлөөлөл үзүүлэх арга тодорхой бус байна.

[Сөрөг нөлөөллийг бууруулах/ Эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйлийн тархацыг нэмэгдүүлэх](#)

Өнгөрсөн аудитаас хойш өвлийн сарууд үргэлжилсэнтэй холбогдон өөр ахиц дэвшил гараагүй. ОТ нь эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын төрөл зүйлийг өмнө цуглуулсан үрээр тарьж үржүүлэх аргын талаар мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинэ үр цуглуулах ажлаа үргэлжлүүлж байна. Ургамлын тархалтын зураглал гаргаснаар амьдрах тохиромжтой орчны талаар мэдээлэл мэдлэгтэй болсон нь энэ төрөл зүйлийг амжилттай үржүүлэхэд тус дэм болох юм. ОТ нь Монгол Улсын Их Сургуулийн судлаачидтай энэ чиглэлээр хамтран ажиллаж, гарч буй ахиц дэвшлийг хянах зорилгоор гурван жилийн судалгааны төлөвлөгөө боловсруулаад байна. Энэ жил тохиромжтой цаг хугацаанд нь Грубовын хөөндийн үрийг дахин цуглуулж нөөцлөх шаардлагатай.

[Нөхөн сэргээлт](#)

Өнгөрсөн аудитаас хойш өвлийн сарууд үргэлжилсэн тул нэмэлт нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байна.

[Бор Овоогийн булаг](#)

Өнгөрсөн аудитаас хойш өвлийн сарууд үргэлжилсэн тул өөрчлөлт ороогүй

[Хаягдал чулуулгийн овоолгыг ургамалжуулах туршилт](#)

ХЧО-г ургамалжуулах туршилтын хүрээнд 2017 оны 12-р сарын 1-4-ний хооронд хөрсний доод давхарга болон өнгөн хөрсөөр хучих ажил хийгдсэн. Ил уурхайн хүнд машин механизмын тусламжтайгаар хөрс шороог буулгаж, янз бүрийн зузаантайгаар тараасан. Үрсэлгээг хаврын хавсарга өнгөрсний дараа буюу 2018 оны 5-р сарын сүүлч, 6-р сарын эхээр устай үрсэлгээ, хуурай үрсэлгээний аргын аль нэгийг ашиглан хийхээр төлөвлөж байна.

[Замын хөдөлгөөн, тээвэртэй холбоотой нөлөөллийн удирдлага](#)

2017 оны 10-р сард баримт бичгийн аудит хийгдсэнээс хойш ОТ-н тээврийн хэрэгсэл зэрлэг амьтан мөргөж гэмтээсэн осол аваар гараагүй. Харин ОТ-Гашуунсүхайтын зам дээр ОТ-н бус гадны тээврийн хэрэгсэлд нэг хулан, нэг хар сүүлт, хэд хэдэн тэмээ мөргүүлэн осолдсон тохиолдлууд гарсан. ОТ нь Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө (БОЯБҮАТ), Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө (БОЯБМТ), Замын нөлөөллийг бууруулах стратегийн дагуу осол зөрчилд хяналт тавин, шаардлагатай арга хэмжээг авч байна.

Замын нөлөөллийг бууруулах хяналтын зөвлөлөөс эдгээр төрөл зүйлийн хувьд цэвэр эерэг нөлөөлөл бий болгох хамгийн сайн арга зам буюу ОТ-н оруулах хамгийн том хувь нэмэр бол сөрөг нөлөөлөл хамгийн их үчрүүлж буй эх үүсвэрт (одоогоор энэ нь ОТ-Гашуунсүхайтын зам биш) чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлж, энэ хөтөлбөрийн хүрээнд ОТ-н олж авах шинжлэх ухааны мэдлэгт тулгуурласан арга хэмжээ хэрэгжүүлэх

замаар биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллыг амжилттай хэрэгжүүлж, хуримтлагдсан нөлөөллийг Өмнөговьд цаашид урт хугацаанд багасгах явдал гэж үзэж байна.

Хулангийн шилжилт хөдөлгөөнийг 2018 онд үргэлжлүүлэн хянаж байгаа бөгөөд шилжилт хөдөлгөөний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Биологийн олон янз байдлын үндсэн хяналт шинжилгээ (БОЯБҮХШ)-ний тайланд тусгасан. ОТ-Гашуунсүхайд чиглэлийн замыг хөндлөн дайрч нүүдэллэсэн хулангийн хөдөлгөөний тоо Биологийн олон төрөл зүйлийн хяналт үнэлгээний хөтөлбөр (БОТЗХҮХ)-т заасны дагуу ногоон босго үзүүлэлтээс даваагүй байна.

Замын нөлөөллийг бууруулах хяналтын зөвлөлөөс өгсөн зөвлөмжтэй холбогдуулан, мониторингийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй байна: GPS хүзүүвчийн тусламжтайгаар хулангийн хөдөлгөөнийг үргэлжлүүлэн хянах төлөвлөгөөтэй байна. Хар сүүлт зээр илүү аюул эрсдэлд өртдөг бөгөөд хангалттай судалгаа мэдээлэл байхгүй байгаа учир Зөвлөлөөс хар сүүлт зээрийн хөдөлгөөнийг хянахад илүү анхаарах зөвлөмж өгсөн. 2018 оны 9-10-р сард нэмэлтээр 20 GPS хүзүүвчийг хар сүүлт зээрэнд зүүхээр төлөвлөж байна. Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (ЗАХН)-ээс GPS-н мэдээлэлд тулгуурлан хулангийн шилжилт хөдөлгөөн, нүүдэлд жил бүр үнэлгээ хийдэг.

ЗАХН болон ЗНБХ-ын зөвлөлөөс өгсөн зөвлөмжийг үндэслэн 2018 оны 1-р улиралд Замын нөлөөллийг бууруулах стратегийг шинэчлэн, Зээлдүүлэгчдэд хүргүүлсэн. Энэ стратеги нь дараах 4 үндсэн чиглэлтэй бөгөөд мониторинг ба дүйцүүлэн хамгаалалд гол ач холбогдол өгсөн байна:

- 1) Замын нөлөөллийг бууруулах хяналтын зөвлөл байгуулж, дэмжлэг үзүүлэх;
- 2) ОТ-Гашуунсүхайтын замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн тоо болон хурдыг хянах;
- 3) Зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөн, зам хөндлөн гарч буй хөдөлгөөнийг хянах (хулан, хар сүүлт зээрэнд радио дамжуулагч бүхий хүзүүвч зүүх зэргээр);
- 4) Дүйцүүлэн хамгаалах төсөл хэрэгжүүлж, Өмнийн говийн бүс нутагт хуримтлагдсан нөлөөллийг удирдахад хувь нэмэр оруулах зэрэг болно.

Хяналт шинжилгээний үр дүнгээр дан ганц дүйцүүлэн хамгааллын төсөлд найдалгүй менежментийн өөр арга хэмжээ тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж гарвал нөлөөлөл шатлан бууруулах чиглэлээр өмнө нь хийсэн ажлыг дэмжих тодорхой нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй гэж БОНХЗ үзэж байна (тухайлбал “Хяналт шинжилгээний үр дүнд үнэлгээ хийж, нөлөөлөл бууруулах арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тогтоох”). Замын хөдөлгөөн зохицуулах, амьтдыг тодорхой байршлуудаар зам гаргах арга хэмжээ байж болно (тухайлбал амьтдын зам хөндлөн гардаг гарцуудыг илүү сайжруулж болно).

Зээлдүүлэгчдээр Замын нөлөөлөл бууруулах стратегийг батлуулснаар энэ зөрчлийг хаасан. Гэсэн хэдий боловч ОТ компани амьтдын зам хөндлөн гардаг тодорхой гарцуудыг ашиглах экологийн үндсийн талаарх ойлголтыг сайжруулахад цаг, хөрөнгө зарцуулах хэрэгтэйг БОНХЗ санал болгож байна. Энэ нь “хулангийн шилжилт хөдөлгөөнд нөлөөлдөг хүчин зүйлсийг харуулсан нарийвчилсан загвар” боловсруулах, “ус, бэлчээрт хүрэх, нийллэгт орох, унагалах” зэрэг шаардлагаар зам хөндлөн гардаг эсэхийг эцэслэн тогтоох тухай мэргэжилтний зөвлөмжтэй нийцэж байна. БОНХЗ хяналт шинжилгээний сайн тогтолцоо бий болгоход хөрөнгө оруулж байгааг сайшааж байна. Үүн дээр нэмж хэлэхэд зам хөндлөн гардаг байршлуудыг тогтоон, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар илүү сайн ойлголттой болохын тулд судалгаа хийж, бодит нотолгоо цуглуулан, үр дүнг нь Замын нөлөөлөл бууруулах стратегид тусгах нь чухал. Мөн ирээдүйд замын сүлжээ өргөжиж, замын хөдөлгөөн ихсэх тохиолдолд нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг (эсвэл шаардлага байхгүйг) батлахад дээрх үр дүнг ашиглах нь чухал юм. Судалгаагаар цуглуулсан бодит нотолгоо, үр дүнг цэвэр эерэг нөлөөлөл авчрах дүйцүүлэн хамгааллын төслийн хэрэгжилтийг дэмжихэд ашиглах боломжтой.

Хааяа 100 км урт машины дараалал үүсдэг Монгол - Хятадын хоорондох нүүрс тээврийн замтай харьцуулахад ОТ-н зам зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад болох, бэлчээрийн талбай хуваах зэрэг

нөлөөлөл харьцангуй багатай. ОТ-н мэдээлснээр Засгийн газар 2017 оны 12-р сараас нүүрс тээврийн замын ачаалал болон замгүй газраар тээврийн хэрэгсэл жолоодох явдлыг бууруулах арга хэмжээ авч эхэлсэн. БОНХЗ энэ талаарх ЗГ болон ОТ-н захидал харилцааны бүртгэлийг харах хэрэгтэй байгаа.

Бохирдлын нөлөөллийн удирдлага

Тоосжилтын хяналт шинжилгээ

Бэлчээрт тоосжилтоос үзүүлж болзошгүй нөлөөллийн талаарх Монгол хэл дээрх тайлангийн төслийг 2017 оны 4-р сард ОТ-д танилцуулсан. Уг тайлангийн хувийг БОНХЗ-д өгч, дараагийн аудитын явцад хянуулах болно.

Селен

Өнгөрсөн аудитаас хойш ХХБ-ийн ойролцоо шувуу, шувууны үүр бүртгэгдээгүй. Өвлийн улирал байсан тул шувуу үүрлээгүй байх.

2017 оны туршид ХХБ-ийн усны чанар харьцангуй тогтвортой байсан. 2017 оны дээжийн дүнгээр селений агуулга 0.1 мг/л ба түүнээс бага байв. 2017 оны 11-р сараас 2018 оны 3-р сар хүртэл шүүрлийн сангийн ус хөлдүү байсан тул дээж аваагүй ба гэссэний дараа хяналт шинжилгээг эхлүүлсэн.

Өнгөрсөн аудитаас хойш биологийн төрөл зүйлд нөлөөлсөн өөр тохиолдол бүртгэгдээгүй.

Эерэг нөлөө ахиу үзүүлэх, дүйцүүлэн хамгааллын менежментийн төлөвлөгөө

ОТ компани Эерэг нөлөө ахиу үзүүлэх урьдчилсан тооцоо, Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу биологийн олон янз байдлын үлдэгдэл нөлөөллийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэн, Өмнийн говийн биологийн төрөл зүйлд эерэг нөлөө ахиу үзүүлэхэд дэмжлэг болох ажлуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Аудитын явцад биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй 4 төслийн талаар мэдээлэл авсан. Үүнд:

“Хулгайн антай тэмцэх” төсөл: БОНХЗ хулгайн антай тэмцэх төслийн жилийн тайланг хүлээж авсан. Төлөвлөсөн ажлууд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Хэдийгээр Хулгайн антай тэмцэх хөдөлгөөнт баг, Хамтарсан эргүүл зэрэг зарим төлөвлөгөөт ажил саатсан хэдий ч эдгээр асуудлууд шийдэгдэж, багууд хэвийн ажиллагаагаа сэргээж ажиллаж эхэлсэн. Мэдээллээс үзэхэд хулгайн ан буурч байгаа ч үүнийг илүү урт хугацаанд цуглуулсан мэдээллээр баталгаажуулах ёстой. Хулангийн хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд уст цэг дээр төвлөрч ажиллавал тавьсан зорилтод хүрэх боломжтой ба уг үр дүнг хяналт шинжилгээний менежментэд оруулж байгаа. Өрхийн судалгааны үр дүнгээр загийг түлшинд, хар сүүлт, хулангийн махыг хүнсэнд хэрэглэх явдал буурсан байна (2015-2017). Хулгайн антай тэмцэх төслийн нэг бүрэлдэхүүн хэсэгт ховор ургамал хууль бусаар түүхтэй тэмцэх ажлууд багтдаг.

“Тогтвортой ноолуур” төсөл: ЗАХН-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар байгаль орчны судалгааны “Артүр Райлэ” хүрээлэнтэй хамтран гаргасан бэлчээрийн төлөв байдлын үзүүлэлтүүд ОТ-н бэлчээрийн төлөв байдлын хяналт шинжилгээнд томоохон хувь нэмэр оруулна. Ноолуурын борлуулалт 2018 оны 4-р сард эхэлсэн хэдий ч үр дүн нь аудит хийх хугацаанд гараагүй байсан тул өмнөх зөвлөмж хэрэгжсэн эсэхийг үнэлэх боломжгүй байлаа. Бэлчээрийн гарц сайн байсан газар нутгийн GPS хүзүүвчний (ямаанд зүүсэн) мэдээллээс үзэхэд ямаанаас үүдэлтэй бэлчээрийн даац хэтрэлт маш бага (1 км) талбайд ажиглагдсан бол бэлчээрийн гарц тааруу байсан газар нутгийн ямаан сүрэг нэлээн хол зайд бэлчээрлэсэн дүр зураг ажиглагдсан. Малын тоо толгойг бэлчээрийн нөөцөд тохируулан бууруулахыг урамшуулсан хөтөлбөр боловсруулах чухал ажил хийгдэж байна. Тогтвортой амьжиргааг дэмжих ажлууд мөн явагдаж байгаа ба ОТ Монголын банкуудтай бичил зээлийн талаар яриа хэлцэл хийхээр төлөвлөж байна.

Цахилгаан дамжуулах шугамын шон дээр богино холболтын тусгаарлагч суурилуулах ажлыг өргөтгөх төсөл: 15 кВ-ын 330 км урт цахилгаан дамжуулах шугамд тусгаарлагч нэмж суурилуулах төслийг эхлүүлэх хүрэл 2017 оны 11-р сард болж, хэрэгжилт нь мөн сардаа эхэлсэн. Уг төслийн гүйцэтгэгч байгууллага (WSCC) өвлийн саруудад хэд хэдэн ажил гүйцэтгэсэн ба тусгаарлагч суурилуулах ажлыг 2018 оны 2-р улиралд дуусгах хуваарьтай ажиллаж байгаа.

Цахилгаан дамжуулах шугамын стандарт боловсруулахад санал өгсөн ба энэ нь гүйцэтгэгч байгууллагын (WSSC) гэрээнд нэмэлтээр орно. Ажлын хүрээнд шувуунд ээлтэй, бага/дунд хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын стандарт, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийн ТЭЗҮ боловсруулах ажил орно.

Төмөр замын дагуух торон хашааг буулгах төсөл: Төмөр замын дагуух торон хашааг буулгах туршилтын төсөлд шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан. Төсөл эхлүүлэх хурал 2018 оны 4-р сарын 10-нд болж, бүх талууд оролцсон.

Хяналт шинжилгээ, хөрвөх менежмент

Нэг жилийн хяналт шинжилгээний ажлын дараа ихэнх үзүүлэлт, босго утга дэвшүүлсэн зорилтдоо хүрсэн боловч зарим нь хүрээгүй байна. 2017 онд хоёрхон үзүүлэлт үлбар шар босго утгаас давсан. Нэг нь “хулгайн антай тэмцэх дүйцүүлэн хамгааллын төслийн талбай дахь амьтны сэг зэмийн нягтшил” 2016 онд 1/200 км² байсан бол 2017 онд 1/52,6 км² болж өсчээ.

Зарим үзүүлэлт (P1, P11) байхгүй, мөн бэлчээрийн төлөв байдлын үзүүлэлт (P2) -ийн босго утга байхгүйн улмаас олон үзүүлэлтийг хяналт шинжилгээгээр гаргах боломжгүй болж байна. Бэлчээрийн төлөв байдлын үзүүлэлт саяхан гарсан ба бусдыг нь засгийн газар боловсруулж гаргах шаардлагатай байгөөгөөс энэхүү нөхцөл үүсэж байна гэж үзэж байна. 2017 онд дараах биологийн төрөл зүйлийн хяналт шинжилгээ хийгээгүй. Үүнд туурайтан амьтдын популяцын судалгаа; хар сүүлт зээрийн шилжилт хөдөлгөөнийг хянах GPS хүзүүвч; аргалийн популяцын хэмжээ, тархац; жороо тоодог / махчин шувуу; нас гүйцсэн заг мод; ховор ургамлын судалгаа; боржингийн илэрцтэй талбайн ургамлын ховор ургамлын зүйлд судалгаа орж байна. ОТ-н уурхайн талбайн хяналт шинжилгээгээр сар бүр зэрлэг амьтад (Могойч загалай, жижиг хөхтөн амьтад, ОТ-н лицензийн талбай дахь туурайтан амьтад, шувууны судалгаа, ХМТ-ийн орчмын хэрээний тоо толгой), замын хөдөлгөөн, “Бор овоо” булаг, амьтан дайрсан осол, хууль бус ангийн судалгаа хийсэн. ЗАХН уурхайн талбайн гаднах хяналт шинжилгээгээр хулангийн шилжилт хөдөлгөөн, унаганы тоо толгой, сэг зэм, бэлчээрийн төлөв байдал, хайлаас, тоорой, ховор ургамал, 220 кВ болон бага, дунд хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, ОТ-ГС чиглэлийн зам, жижиг хөхтөн амьтад, шувуу үргээх хэрэгслийн судалгаа болон ОТ-н дэд бүтцийн дагуу зэрлэг амьтдын ажиглалт хийсэн.

Хүний нөөц

Өмнөх аудитаас хойш ОТ-н хүний нөөц, УБ руу шилжсэн ажилтнууд, гэрээт байгууллагын хүний нөөцөд өөрчлөлт гараагүй. Ургамал, амьтан, хяналт шинжилгээ хариуцсан багийн хэд хэдэн гишүүн 2018 оны зуны жасаагаа өөрчилж, уурхайн талбайд илүү удаан хугацаагаар ажиллана. Эдний зарим нь уурхайн талбайд байнга байрлан ажиллах бол үлдсэн нь ердийн жасааны хуваариар уурхайн талбай болон УБ-т ажиллана.

Хулан, хар сүүлтэд хүзүүвч зүүх төлөвлөгөөт ажлаас голлон шалтгаалж 2018 оны БОЯБҮХШ-ний төсөв нэмэгдсэн.

Биологийн төрөл зүйлийн хяналт шинжилгээ, дүйцүүлэн хамгааллын бүх төслийг олон жилийн гэрээ байгуулан хэрэгжүүлж байна. ЗАХН, Экоминерал ХХК гэрээний дагуу 2020 он хүртэл үйлчилгээ үзүүлнэ. 2018 оны 1-р улиралд “Глобал биодиверсити консэрвэшин” байгууллагатай 3 жилийн шинэ гэрээ байгуулсан.

Нийгэм

Хөдөлмөрийн нөхцөл

ОТ-н ажиллах хүчний судалгааны тайланд дурдсанаар 2018 оны 2-р сарын 28-ны байдлаар ОТ-н үндсэн болон гэрээт ажилчдын тоо 14,037 хүрч, өмнөх аудитаас хойш 1,192-оор нэмэгджээ. Үүнд УБ, Даланзадгад, Ханбогд сумаас уурхайн талбайд ирж ажилладаг ажилчид багтсан. Өмнөх аудитаар нийт ажилчдын 93.82%-ийг Монгол ажилчид бүрдүүлж байсан бол энэ удаа 93.8% болж 13,169-д хүрчээ. Олборлолт, уул уурхайн чиглэлийн гэрээт ажилчдын 98.18%-ийг (75-аас доошгүй хувийг дотоодоос

бүрдүүлэх шаардлага), барилга угсралтын чиглэлийн гэрээт ажилчдын 90.62%-ийг (60-аас доошгүй хувийг дотоодоос бүрдүүлэх шаардлага) дотоодоос бүрдүүлж, ХӨОГ-ний шаардлагыг биелүүлсэн байна.

Өмнөх аудитаас хойш Өмнөговь аймгаас авсан ажилчдын тоо 355-аар нэмэгдсэн. 2-р сарын 28-ны байдлаар Өмнөговь аймгийн 2,635 ажилтан ОТ-д ажиллаж байгаагийн 55.1% нь Ханбогд, 30.4% нь Даланзадгадын иргэд байна. Эдний 20 нь удирдах албан тушаал, 23 нь инженер, мэргэжилтэн, 173 нь оператор, 104 нь мэргэжилтэй ажилчин, 2,315 (87.9%) нь уул уурхайн бус албан тушаал хашиж байна.

Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ үргэлжилж байгаа. Уурхайн талбай дээр заавал байрлах шаардлагагүй зарим ажлын байрыг УБ, Даланзадгад, Ханбогдын оффис руу шилжүүлэх ажлын хэрэгжилт 2018 оны 1-р сард дууссан ба нийт 237 ажлын байрыг шилжүүлсэн. ОТ Өмнөговь аймгийн мэргэжил, үр чадварын мэдээллийн сан бүрдүүлж, тэднийг ажлын байраар хангах ажлаа үргэлжлүүлж байна. 2018 оны 2-р сарын 28-ны байдлаар тус мэдээллийн санд 1,667 иргэдийг бүртгэжээ. ОТ-н Ханбогд суман дахь хүний нөөцийн ажилтан орон нутгийн иргэдэд ОТ болон түүний гэрээт байгууллагуудын сул орон тоонд ажилд орох өргөдөл гаргахад нь тусалж, ажил хайгсдад сайн өргөдөл бичих талаар сургалт өгдөг.

ОТ, Өвөр Монголын Өөртөө засах орон хоорондын хамтын ажиллагааны хүрээнд төлөөлөгчийн газар байгуулах ажил ахицтай байгаа ба 2018 оны 4-р сард ажилчдаа бүрдүүлэн нээхээр төлөвлөж байна.

Өмнөх аудитаас хойш ОТ-н гомдол санал хүлээн авах систем “Спийкаут”-аар хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил, луйвар, ялгаварлан гадуурхал, хүний нөөц бүрдүүлэлт, ажилчдын болон ажлын байрны эрүүл ахуйтай холбоотой 36 гомдол ирсэн. Нийт ирүүлсэн гомдлын ангиллаар авч үзэхэд дээрэлхэж доромжилсон тохиолдол дийлэнхийг эзэлж байгаа ба энэ төрлийн 7 гомдлын 3 нь нотлогдсон бол 2-ыг судалж байна.

Гэрээт ажилчдын хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн харилцааны удирдлагын төлөвлөгөө (ХХУТ), гэрээт ажилчдын цалингийн шатлал, судалгаа, хөдөлмөрийн харилцааны аудит, сарын тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт зэргийг багтаасан хөтөлбөрийн дагуу зохицуулдаг. Төслийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгын хүрээнд ХХУТ-ний гэрээг 15 том гэрээт компанитай байгуулсан. Эдгээрийн дотроос 14 компани дээр ХХУТ-ний аудит хийж, 12 компани засаж сайжруулах арга хэмжээ авсан бөгөөд 2 нь одоо хийгдэж байна. Дотоод хяналтаар гэрээт компанийн ажилчдын оролцоог сайшаан урамшуулах хөтөлбөр зэрэг сайшаалтай үр дүн гарсны хажуугаар баримт бичгийн хяналт, сахилга бат, дэг журмын удирдлага зэрэг анхаарах асуудлууд ч байна. Дотоодын бизнесийн чадавхийг бэхжүүлэхэд гэрээт ажилчдын хөдөлмөрийн харилцааны үүрэг, ОТ-н, тэр дундаа Өмнөговь дахь оффисын хүний нөөцийн мэргэжилтнүүдийн дэмжлэгийг БОНХЗ онцлон тэмдэглэж байна.

Гүний уурхайн төсөл дээр ажиллаж буй ОТ, Рио тинто, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллагууд “Нэг ОТ” гэсэн нэгдмэл соёл төлөвшүүлэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа уялдуулах зорилготой “Хамтдаа” хөтөлбөрийн хэрэгжилт үргэлжилж байна. Үүний хүрээнд 2 өдрийн семинарыг 41 удаа зохион байгуулж 913 ажилтан, манлайлын/амжилтын семинарыг 149 удаа зохион байгуулж нийт 3,201 ажилтан хамруулжээ. “Удирдах ажилтны зан төлөв” гэсэн 30 минутын танилцуулгыг ажил эхлэхийн өмнөх 55 удаагийн уулзалт дээр танилцуулж, 3,667 үндсэн болон гэрээт ажилтанд хүргэж, үнэтэй санал хүсэлт авсан байна.

2-р сард ОТ-н хүний нөөцийн менежерүүд ҮЭ-тэй хамтран Хамтын гэрээг (2016-17) хянан хэлэлцсэн. Тэд Хамтын гэрээний биелэлтийг 98% гэж дүгнэсэн ба УБ, Даланзадгадаас бусад газраас ирж очин ажилладаг ажилчдын аюулгүй ажиллагаатай холбоотой 2 асуудал биелэгдээгүй байна. Биелэгдээгүй 1 заалт нь ажилчдын багахан хувьд хамаарах ба тэд уг асуудлыг ОТ-д олон жил дэвшүүлж байгаа. Үүнийг эс тооцвол Хамтын гэрээг шинэчлэн байгуулах талаар тохиролцоонд хүрэх төлөвтэй байна.

ОТ-н уурхайн талбайд Оюут, Манлай, Эрчим хүчний гэсэн 3 кемп ажиллаж байна. Оюут II кемпийн тал нь ашиглалтад орсон. Уурхайн талбайгаас гадна Ханбогд сумын ойролцоо байх Зуны кемпэд ОТ-Ханбогд чиглэлийн зам барилгын ажилчид болон уурхайн талбайн кемпийн зай талбай хүрэлцээгүйн улмаас уурхайн зарим ажилтан байрладаг. Ажиллах хүчний тооцоо, бодит хэрэгцээ, орон байрны хүчин чадлын талаарх тоо баримт зөрүүтэй байдаг. Менежментийн тодорхой арга хэмжээ авахгүй бол 2018 оны 12-р

сар хүртэл орон байрны хүчин чадал, орон байрны хэрэгцээ шаардлагыг төлөвлөснөөр хангах боломжгүй харагдаж байна. Хамгийн их хэрэгцээ 2018 оны 5-р сард үүсэж, 1,152 ор дутагдах төлөвтэй байна. Оюут-II кемпийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг уг асуудлыг шийдэх янз бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. ОТ-н кемпийн 10 жилийн мастер төлөвлөгөөндөө тусган, ажилчдаа хангалттай, хүрэлцээ сайтай орон байр, амралтын байгууламжаар хангахыг БОНХЗ онцлон тэмдэглэж байна. Баримт бичгийн аудитаар уг орон байрны дутагдал нь дам, сөрөг нөлөө, асуудал үүсгэж байгаа эсэхийг БОНХЗ тодорхойлох боломжгүй байсан тул дараагийн аудитаар уурхайн талбайд очихдоо ажилчдын орон байр Зээлдүүлэгчдийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг авч үзнэ.

Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөр, амьжиргаа сайжруулах хөтөлбөр

Өмнөх аудитаар биелэгдээгүй байсан ажил нь эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан малчин өрхүүдийг хамарсан Үр дүнгийн үнэлгээ байсан. Үр дүнгийн үнэлгээг 2017 оны 10-12 дугаар сард хийж, үнэлгээнд хамрагдсан 92 өрхийн амьжиргаа “үндсэн” болон “амьжиргааны өргөн хүрээний” үзүүлэлтүүдийн дагуу сэргэж сайжирсан эсэхийг тодорхойлоход анхаарсан. Үр дүнгийн үнэлгээний тайлан боловсруулалт дуусах дөхөж байгаа ба уг тайлан малчин өрхүүдийн амьжиргаа сэргэсэн, сайжирсан, доройтсоныг бодитоор харуулах боломжийг ОТ-д олгоно гэж үзэж байна. Үр дүнгийн үнэлгээнд уг ажлыг дэмжих одоо хэрэгжиж байгаа болон нэмэлт арга хэмжээний талаар зөвлөмж гарах байх. Үр дүнгийн үнэлгээг амжилттай хийж дуусах хүртэл М1.23 дугаартай асуудлыг хаахгүй.

Зам засварын ажил гүйцэтгэх гэрээ дууссаны дараа /бодитоор бус/эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан 92 малчин өрхийн гишүүдэд зориулж Тогтвортой амьжиргаа дэмжих сургалт зохион байгуулж, нөхөн олговор авсан малчдыг амьжиргаа, мал аж ахуйгаа тогтвортой эрхлэх үр чадварт сургасан. 12 сарын танхимын болон дадлага сургалтыг Дорнод аймгийн Политехникийн коллежийн тусламжтайгаар зохион байгуулсан. Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан өрхүүдээс 11 нь амьжиргаандаа сэтгэл хангалуун байгаа тул Тогтвортой амьжиргаа дэмжих сургалтад оролцоогүй ба 52 өрхийн тус бүр нэг гишүүн тогтмол ажилтай зэргээс шалтгаалж уг сургалтад 35 хүн хамрагдсан.

Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ сумын захиргаа, ТББ-уудын төлөөлөл болон усны менежмент, малын эрүүл мэнд, мал эмнэлгийн мэргэжилтнүүдийг оролцуулан “Говийн оюу” хөгжлийг дэмжих сангийн 3 жилийн стратеги боловсруулах сэдэвчилсэн семинар зохион байгуулсан. “Бэлчээрийн үнэлгээ” төслийг аймгийн захиргаанаас хэрэгжүүлж буй бэлчээртэй холбоотой үйл ажиллагаатай нэгтгэн уялдуулж дан ганц Ханбогд суманд бус нийт Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байна. Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй “Бэлчээр, ус”-ны төслөөр Ханбогд, Баян-Овоо, Манлай, Цогт-Овоо сумдад 77 үст цэг шинээр гаргах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, гар худаг засах зэрэг ажлууд төлөвлөсөн. Эдгээрийн нийт зардал 820 гаруй сая төгрөг болох ба “Говийн оюу” сангаар дамжуулан санхүүжүүлнэ. Уг менежментийн төлөвлөгөөний дагуу уурхайн үйл ажиллагаа явагддаггүй 3 суманд “Говийн оюу” сангийн 139 сая төгрөгийн санхүүжилттэй “Шилмэл сүрэг” төсөл хэрэгжүүлж байна. Уг төсөл нь мал сүргийг бүртгэлжүүлэх, тэжээлийн чанар сайжруулах чиглэлийн ажлуудыг дэмжих юм. Уурхайн үйл ажиллагаа явагддаг болон явагддаггүй сумдад хэрэгжүүлж буй бэлчээрийн менежментийн эдгээр төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг БОНХЗ сайшаан тэмдэглэж байна.

Ханбогд сумын Халамжийн хэлтэстэй хамтран боловсруулсан Эмзэг бүлгийн өрхүүдийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт аудит хийх хугацаанд үргэлжилж байв. Уг хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн өрх болон хувь хүмүүсийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс гадна эмзэг өрхүүдэд зориулан хөрөнгө босгох/соёлын арга хэмжээг хагас жил тутамд зохион байгуулж байна. Ханбогд сумтай хамтран гаргасан 2018 оны эмзэг өрхийн жагсаалтад нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан өрх байхгүй байгааг БОНХЗ онцлон тэмдэглэж байна. Түүнчлэн Үр дүнгийн үнэлгээнд эмзэг бүлгийн өрхөд чиглэсэн хэрэгжүүлж байгаа болон төлөвлөсөн ажлын талаар тусгай бүлэг байгааг энд нэмж тэмдэглэх нь зүйтэй. Үр дүнгийн үнэлгээний тайланд нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан эмзэг бүлгийн өрхүүдтэй холбоотой үр дүнг бүрэн гүйцэд тусгах нь чухал гэж үзэж байна.

Оролцогч талуудын хамтын ажиллагаа

Тодорхой сонирхлын бүлгүүдийн оролцоотой оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд багийн иргэдийн хуралд оролцож, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан болон ХХБ-ийн доод хэсгээр нутагладаг өрхүүдийн асуудал зэрэг үйл ажиллагаа багтсан. Ханбогд сумын төвд Иргэдийн хөгжлийн төв үйл ажиллагаа явуулж байгаа ба тайлант хугацаанд 805 удаа утсаар мэдээлэл өгч, 1,586 иргэнийг хүлээн авчээ. Даланзадгадын оффис 42 утасны дуудлага, 1,685 иргэнийг хүлээн авсан байна. ОТ-н уурхайн талбайн аялалд иргэдийн 9 бүлгийн 333 хүнийг хамруулсан ба 660 үндсэн болон гэрээт ажилтан Ханбогд сумын захиргаатай хамтран зохион байгуулсан “Ханбогдод тавтай морил” мэдээллийн арга хэмжээнд оролцжээ.

Хамтын ажиллагааны бүртгэл, тэмдэглэлийг ОНХНХ-ын баг үргэжлүүлэн хийж, оролцогч талуудын хамтын ажиллагааны хандлага, хариу арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж байна. 2017 оны 4, 2018 оны 1-р улиралд хамтын ажиллагааны арга хэмжээнд 1,459 хүн хамруулсан тухай 94 бүртгэл байна. Ийнхүү хамтран ажилласнаар өмнөх аудитаас хойш талууд илүү эерэг ойлголт, хандлагатай болж өөрчлөгдсөн байна. Нээлттэй өдөрлөг зохион байгуулах, сар бүр орон нутгийн сонин гаргах, вэб сайт дахь мэдээллээ шинэчлэх байдлаар түншлэгч сүмд болон бусад оролцогч талуудад мэдээлэл хүргэж байна. Сар бүр 4,400 ширхэг орон нутгийн сонин тараасан нь өмнөх аудитын үеэс 2 дахин нэмэгджээ. Сонинд улирлын ажлын үзүүлэлт, санал гомдолд хариу өгч шийдсэн байдал, бусад үзүүлэлтүүдийг шинэчлэн гаргадаг. Эдгээр үр дүн болон ОНХНХ-ын багийн орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй системийг сайшаах нь зүйтэй юм.

Аудитын хугацаанд хүлээн авсан гомдлын тоо цөөн байсан ба хамгийн сүүлд 2-р сард санал гомдол хүлээж авсан. Тайлант хугацаанд 4 санал гомдол хүлээн авч, 2-ыг нь шийдсэн байна. Байгаль орчны тухай хоёр, нөхөн олговор, малчдын оюутан хүүхдэд олгох тэтгэлэгтэй холбоотой тус бүр нэг гомдол ирсэн. Мөн хугацаанд нэг эерэг санал байв. Эдгээр нь иргэдийн Компанийн талаарх ерөнхий ойлголт болон үндэслэлтэй хүсэлтийг хүлээн авдаг гэсэн итгэлийг харуулж байгаа юм.

Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсман Гурван Талт Зөвлөлийн талуудтай гэрээ байгуулж, 65 ажил бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан. ОТ өөрийн хариуцсан 13 ажлаа хэрэгжүүлсэн. Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсманы хяналт шинжилгээ 2018 оны 5-р сард дуусах ба үүний дараа ГТЗ гомдлыг хаах эсэх байр сууриа 5-р сарын хурал дээр танилцуулна. ГТЗ-ийн байр суурь, бусад мэдээлэлд үндэслэж Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсман гомдлыг хаах эсэх талаар дүгнэлт гаргана. БОНХЗ уг үйл явцын үр дүнтэй танилцана.

Байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил дуусаж, байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээг хариуцах “Мөнх ногоон галба” ТББ-ыг 2017 оны 11-р сард шинээр байгуулсан ба уг ажлыг тодорхой үнэ төлбөртэйгөөр хийж гүйцэтгэх юм. Уг ТББ-ын удирдлага зохион байгуулалтыг тодорхойлон тохирцолсон ба ус, бэлчээр, агаарын чанар, амьтан, Ундай голын экосистемийн зэрэг 5 хяналт шинжилгээний цэгийг тодорхойлж байгаль орчны мэдлэг мэдээлэл дээшлүүлэх ажлыг гүйцэтгэж ажиллах 6 ажлын байрыг баталсан.

Бүс, орон нутгийн хөгжил

Бүс, орон нутгийн хөгжил нь ОНХНХ-ын багийн гол үүргийн нэг бөгөөд Өмнөговь аймагтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээгээр дамжин хэрэгждэг. Энэ үйл ажиллагааг ОТ хөгжлийг дэмжих сангаар дамжуулан санхүүжүүлж, Харилцааны хороо, ХДС-ийн ТУЗ-өөс удирдан, орон нутгийн хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжүүлдэг. Хамтын ажиллагааны гэрээг 2015 оны 4-р сараас эхлэн хэрэгжүүлж байгаа ба гэрээний дагуу “Говийн оюу” ХДС-г ажиллуулдаг. Энэ хугацаанд 15.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 72 төсөл хэрэгжүүлсэн ба гуравны хоёр нь Ханбогд, Даланзадгад сумын нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн төслүүд байсан. ХДС-гийн хяналт үнэлгээний бүтцийг баталж байгаа нь тус сангийн санхүүжилтээр болон хамтран санхүүжүүлсэн хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, үр дүнг нэгдсэн арга замаар удирдахад чухал ач холбогдолтой.

2017 онд “Ирээдүй хойч үе” сангаас (ХДС-ийн санхүүжилтийн 5%) 57 оюутанд 151 сая төгрөгийн тэтгэлэг олгосны зэрэгцээ тайлант хугацаанд ЖДҮ-г дэмжих зорилгоор тус бүр 30 хүртэлх сая төгрөгийн 11 бичил зээл олгосон байна. Тэтгэлэг авсан оюутнууд амжилттай суралцаж байгаагаас гадна зээлийн төлөлт хэвийн явагдаж байгааг ОТ мэдээлсэн.

2017-2018 онд дуусах төлөвлөгөөтэй Ханбогд суманд хэрэгжүүлж буй дэд бүтцийн төслүүдийн нэг нь ОТ-Ханбогд чиглэлийн зам бөгөөд 2018 оны 4-р улиралд дуусах төлөвлөгөөтэй байна. Тус төслийн газар шорооны ажил бараг дууссанаас гадна хайрган суурийг тавьсан. Гүүр, ус зайлуулах хоолойн ажил эхэлж байна. ОТ-ГС чиглэлийн зам барилгын ажил хүлээгдсэн хэвээр байна.

Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөнд шилжин ирэх хөдөлгөөнийг удирдах төрөл бүрийн арга хэмжээг тодорхойлсон. Тухайлбал хүний нөөц бүрдүүлэлт, худалдан авалт, кемпийн байрны менежментээр дамжуулж ажилчдын амьдрах байрны загварт зохицуулалт хийж, Ханбогд, Даланзадгад сумын хүн амын нийгмийн дэд бүтэц, үйлчилгээг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Тус төлөвлөгөө нь Хамтын ажиллагааны хороогоор дамжин хэрэгждэг. Хөндлөнгийн статустай Хамтын ажиллагааны хороо нь Өмнөговь аймаг болон Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумын тамгын газрын төлөөлөл, ОТ болон ЭОТ-н төлөөлөл, “Говийн оюу” ХДС-ийн төлөөлөөс бүрддэг. Тус хороо дараах 5 ажлын хэсэгт санал зөвлөмж өгдөг. Үүнд: орон нутгийн худалдан авалтын ажлын хэсэг, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэсэг, стратегийн уялдаа холбоог хангах ажлын хэсэг, Ханбогд сумыг хөгжүүлэх ажлын хэсэг, Хамтын ажиллагааны гэрээ хэрэгжүүлэх болон ХДС-ийн Харилцааны хороо. Ажлын хэсгүүд нь Хамтын ажиллагааны хороонд тайлагнах асуудлуудаар шийдвэр гаргах эрхтэй.

Орон нутгийн ажил эрхлэлт, худалдан авалтын ажлуудыг ХАШИХМТ-тэй уялдуулан хийж байна. Өмнөговь аймгийн мэдлэг, үр чадварын мэдээллийн сангийн тусламжтайгаар орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжих ажил үргэлжлэн явагдана. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу тогтмол хуралдаж, үүний үр дүнд 2018 оны 1-р улирлын байдлаар ОТ болон түүний гэрээт компаниудад орон нутгийн 2,746 иргэд ажилд оржээ. Эдний 1,480 нь Ханбогд сумын иргэд байна. Орон нутгийн худалдан авалт нэмэгдэж, үндэсний компаниудтай 722 сая ам.долларын үнийн дүн бүхий гэрээ байгуулжээ.

Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

Эрүүл мэндийн баг нь ЭМААБОАБ-ын хэлтэст харьяалагддаг төвлөрсөн нэгж бөгөөд ажлын байран дахь эрүүл мэндийн үйлчилгээ, олон улсын SOS эмнэлгийн үйлчилгээг хариуцаж ажилладаг. Ажлын байран дахь эрүүл мэндийн үйлчилгээнд өндөр эрсдэлтэй хэсэгт ажилладаг ажилтнуудын дуу чимээ, тоос тоосонцор, цахиур, гагнуурын очид өртөх өртөлтийн хэмжээнд анхаарч ажилладаг. Энэ жил гүний уурхайн төсөл дээр хамгийн олон үндсэн болон гэрээт ажилтнууд ажиллаж байгаа бөгөөд хүний нөөц, чадавхын хувьд эрс нэмэгдсэн. Эрүүл мэндийн багаас Эрүүл ахуйн ерөнхий зөвлөх шинээр томилон ажиллуулж байгаа бөгөөд хяналт шинжилгээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр гүний уурхайн эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн түн ударгүй ажилдаа орохоор бэлтгэж байна. шинээр томилж,. Гүний уурхайн төсөл өндөр эрсдэлтэй ажлууд, дизелийн тортогт үргэлжлүүлэн анхаарч, ус цацруулагч систем болон химийн бодис ашиглан тоосжилт бууруулах системийн туршилтын ажлын үнэлгээг хийж байна.

Уурхайн ажилчдад учирч болох 17 ноцтой эрсдэлд онцгойлон анхаарч, ноцтой эрсдэлийн хяналтын магадлагаа хийх зорилготой Ноцтой эрсдэлийн удирдлага хөтөлбөрийг уурхай даяар хэрэгжүүлж, гүний уурхайн үйл ажиллагаа болон гэрээт компаниудын үйл ажиллагаанд мөн нэвтрүүлсэн. Химийн бодис алдагдах, гал гарах, дэлбэрэлт үүсэх, бусад аюул осол зэрэг үйлдвэрийн үйл ажиллагааны системээс үүдэлтэй болзошгүй аюул эрсдэлийг авч үзэх Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны менежментийн системийг Баяжуулах үйлдвэр, Төв дулааны станц, Максам тэсэлгээний байгууламж, ШТС-д тус тус нэвтрүүлсэн. Ил уурхай, Хаягдал хадгалах байгууламж, Экспортын тээвэрлэлтийн хэлтсүүдийн тээврийн автомашины операторуудын алжаал ядаргааг удирдах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа талаар Эрүүл мэндийн хэлтэс онцлон тэмдэглэсэн.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал

Хаягдал хадгалах байгууламжтай холбоотойгоор орон нутгийн иргэдийн оролцоо, ялангуяа ХХБ-д гэмтэл гарсан тохиолдолд авах арга хэмжээ нь ХХБ-ийн онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний онцгой бүрэлдэхүүн хэсэг юм. ОТ-н ОНХНХ-ын баг орон нутгийн оролцогч талуудын жагсаалтыг шинэчлэн гаргах ажлаа хийж байна. Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй талбайг эцэслэн

тогтоогоогүй байгаа нь ОНХНХ-ын багийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллах боломжийг хязгаарлаж байна. ОНХНХ-ын баг хариуцсан газрыг хяналтдаа байлгахын зэрэгцээ онцгой байдал хариуцсан төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Аудитын хугацаанд орон нутгийн иргэдтэй холбоотой ямар нэг аюул осол, аюулгүй ажиллагааны асуудал гараагүй ба ОНХНХ-ын баг сумын цагдаагийн хэлтэстэй хамтарч гэмт хэргийн мэдээлэл статистикийн хяналтыг үргэлжлүүлж байна. Статистикийн дагуу сум орчмын замаар зорчдог тээврийн хэрэгслийн (ачаа тээврийн машинууд орно) тоо нэмэгдсэнтэй уялдаж, энэ төрлийн зөрчил өссөн байна. Хил дээр 9,000 орчим нүүрс тээврийн автомашины дараалал үүссэн нь Цагаан сарын дараа гэмт хэргийн тоо өсөхөд нөлөөлсөн гэж ОТ мэдээлсэн. Засгийн газар уг асуудлыг шийдэх арга хэмжээ авч, Хятадтай хилийн асуудлаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Түүнчлэн Цагаан хаданд машины зогсоол байгуулах, нийгмийн болон эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээ нэвтрүүлэх талаар төлөвлөж байна. Хэдийгээр Цагаан хадны хилийн боомт нь ОТ-н хариуцах асуудал биш гэдгийг БОНХЗ хүлээн зөвшөөрч байгаа ч ОТ-той холбоотой орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын асуудал хөндөгдөх нөлөөтэй гэж үзэж байна.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн ихэнхийг ХДС-гийн санхүүжилтээр Өмнөговь аймаг, түншлэгч сумд болон шинэ түншлэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Удахгүй “Говийн оюу” ХДС НҮБХС, ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сан, Австралийн засгийн газартай эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 4 жилийн түншлэлийн гэрээ байгуулагдах гэж байна. Өмнөговь аймгийн хэмжээнд эх, нялхсын эндэгдэл улсын дундажтай харьцуулахад хамгийн өндөр байгаа тул дээрх түншлэлийн гэрээний хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын эмэгтэйчүүд, өсвөр, залуу иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хамрагдалтыг сайжруулах юм. Энэхүү хөтөлбөр нь “Говийн оюу” ХДС түншлэгч байгууллагуудтай хамтран бүс нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах сайн жишээ болно гэж БОНХЗ үзэж байна.

Соёлын өвийн менежмент

Аудитын хугацаанд соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, соёлын өвийг сурталчлан таниулах нийт 579 удаагийн сургалт, уулзалт зохион байгуулсан ба харин соёлын өвтэй холбоотой ямар нэг зөрчил бүртгэгдээгүй болно. Дээрх хугацаанд 50 гаруй газар хөндөх зөвшөөрөл олгосон бөгөөд ОТ-н ёс заншлын өргөөгөөр 896 зочин үйлчлүүлжээ. Соёлын өвийн хяналт шинжилгээг 4 газарт үргэлжлүүлэн хийж байна.

Соёлын өвийн хөтөлбөрийн хамрах хүрээг БОНХЗ онцлон тэмдэглэж байна. Ханбогд суманд хэрэгжүүлж буй соёлын өвийн төслүүдэд Шар цав, Хүрдэт агуй орчмоор эргүүл хамгаалалт хийх соёлын өвийн хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх, соёлын өв, палеонтологийн болон байгалийн үзэсгэлэнт газруудын талаар 5 баримтат кино бүтээх ажил, соёлын өвийн хөтөлбөрийн үйл ажиллагааг Ерөнхийлөгчийн соёлын зөвлөхөд танилцуулах зэрэг үйл ажиллагаа багтаж байна.

1 УДИРТГАЛ

“Оюу толгой” төсөл нь (цаашид “Төсөл”, “ОТ төсөл” гэх) Монгол Улсын Өмнийн говийн бүсэд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойд зүгт 80 км-т оршдог. Тус ашигт малтмалын ордыг 2001 онд нээж илрүүлсэн бөгөөд зэс, алт, мөнгө, багахан хэмжээний молибден агуулсан хэд хэдэн бүлэг ордоос бүрдэнэ. Төсөл нь Ил уурхай, Гүний уурхайг хамрах бөгөөд Баяжуулах үйлдвэр өдөрт 100,000 тонн баяжмал боловсруулж, жилд 500,000 гаруй тонн баяжмал үйлдвэрлэх тооцоотой. 2013 оны 7-р сараас хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ тээвэрлэн хүргэж эхэлсэн.

2013 оны 9-р сард “Оюу толгой” ХХК (цаашид “Төслийн компани” буюу “ОТ” гэх) өөрийн хэрэгжүүлж буй “Оюу толгой” төслийн (Монгол Улс Засгийн газар, Рио Тинто групп (цаашид РТ гэх), Туркуойз Хилл Ресурс компани хоорондын стратегийн түншлэл) Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхөөр (БОНХЗ)⁸ Итали улсын Генуя хотод байрладаг Д'Апполониа ХК (2017 оны 6-р сарын 5-с эхлэн “Рина Консалтинг” болсон)-ийг ажиллуулахаар гэрээ байгуулсан. 2012 оноос эхлэн РТ групп нь төслийн бүх хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг төлөөлөн төслийн менежментийг хариуцахаар томилогдсон.

“Рина консалтинг” компани БОНХЗ-ийн хувьд санхүүжүүлэгч байгууллагуудад зориулан 2013 оны 9-р сарын 1-нд эхэлсэн ОТ уурхайн ашиглалтын үйл ажиллагааны Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин (ЭМААБО), нийгмийн асуудалд гол анхаарлаа хандуулан хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх үүрэгтэй. БОНХЗ нь уг үүргийнхээ хүрээнд ОТ төсөл Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөндөө тусгасан байгаль орчин, нийгмийн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг санхүүжүүлэгч байгууллагуудад тайлагнах бөгөөд уг төлөвлөгөө нь БОННУ болон бусад холбогдох бичиг баримтад тодорхойлсон нөлөөлөл бууруулах стратегийг ОТ компани хэрхэн хэрэгжүүлэхийг заасан баримт бичиг юм. Эдгээр нь ирээдүйд тодорхой цаг хугацаатай гүйцэтгэх үйл ажиллагааны жагсаалт, мөн БОНХЗ төслийн Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (БОНЭМАА) гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийхдээ ашигласан лавлагаа баримт бичиг болсон Ашиглалтын БОНМТ-үүдийг агуулсан төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (БОНУАТ) багтаадаг.

Энэ тайланд БОНХЗ-ийн 2018 оны 4-р сард хийсэн Баримт бичигт тулгуурлан хийсэн аудит, мөн хугацаанд Оюу толгой уурхайн талбайн ажилтнуудтай хийсэн теле-хэлэлцүүлгийн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан. Тайланд Төслийн өнөөгийн байдлыг үндсэн үзүүлэлтүүдээр харуулж, өмнөх БОНХЗ-ийн тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах талаар авсан арга хэмжээний мэдээллийг оруулсан. Энэ тайлан дахь мэдээллүүдийг баримт бичгийн дүн шинжилгээ, олон нийтийн хүртээл болсон судалгаа, тухайлсан илтгэл, танилцуулгууд болон ОТ-н ажилтнуудтай хийсэн ярилцлагад үндэслэн болосвруулав. Тус тайланд дурдагдаагүй сэдвүүдийг 2018 оны 3-р улиралд уурхайн талбайд ажиллах БОНХЗ-ийн дараагийн аудитын үеэр авч үзнэ. Энэ үеэр БОНХЗ-ийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ уурхайн талбайд ажиллахаар төлөвлөж байна.

Аудитын үеэр дараах тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- ОТ компанийн өгсөн ЭМААБО, нийгмийн баримт бичиг, төсөлтэй холбоотой бусад баримт бичгийг судлах;
- ЭМААБО, нийгмийн чиглэлийн дүрэм, журмын биелэлтийг хариуцсан багуудтай 2018 оны 4-р сарын 16-26-ны хооронд утсаар ярилцлага хийж, холбогдох төлөвлөгөө, дүрэм журамтай танилцах;
- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө, БОНМХ-т тодорхойлсон үүрэг хариуцлагын хэрэгжилт, биелэлтэд үнэлгээ хийх;

⁸ БОНХЗ-ийн баг: Жиованни Ди Франчи (Төслийн менежер, багийн ахлагч - Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн), Роберт Сноу (Ахлах хянагч - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, үйл уурхайн мэргэжилтэн), Дана Стренгт (Байгаль орчин/Гидрологийн мэргэжилтэн), Анжела Рийман (Нийгмийн /Орон нутгийн харилцааны мэргэжилтэн), Жо Трийвик (Биологийн олон янз байдлын мэргэжилтэн)

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө, БОНМХ-т тодорхойлсон үүрэг хариуцлагаас гажсан буюу зөрүүтэй, дутагдалтай зүйл байгаа эсэхийг тодорхойлж, Салбарын олон улсын тэргүүн түршлагад (СОУТТ) үндэслэн БОЭМАА-г сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх;
- БОНХЗ-ийн 2017 оны 10-р сард хийсэн Аудитын тайлан⁹, мөн оны 12-р сард боловсруулсан БОНХЗ-ийн Усны хяналт үнэлгээний нарийвчилсан тайланд¹⁰ тодорхойлсон дүгнэлт, ажиглалтын мөрөөр гүйцэтгэлийг хянаж, арилсан зөрчлийг хаах;
- БОНХЗ-ийн тайланг (энэ тайлан) боловсруулж, олон нийтийн хүртээл болгох зэрэг үйл ажиллагаа багтсан

Тайланд дурдсан мэдээлэл, ажиглалт, үзэл санаа нь “Рина Консалтинг” компанийнх бөгөөд Төсөл болон/эсвэл давуу эрхтэй Зээлдүүлэгчдээс хараат бус, бие даасан болно. Тайланд дурдагдаагүй сэдвүүдийн тухайд ямар нэг эрсдэлтэй зүйл төслийн хүрээнд илрээгүй болно.

⁹ Рина консалтинг, “Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн нийцлийн хяналт шинжилгээний тайлан – 2017 оны 10-р сар – Явцын тайлан”, баримт бичгийн дугаар 13-391-Н11, 2018 оны 3-р сар.

¹⁰ Рина консалтинг, “БОНХЗ-ийн тайлан: ОТ-н усны нарийвчилсан үнэлгээ – Лондонгийн үүлзалт: 2017 оны 12-р сарын 5-6”, Баримт бичгийн дугаар 13-391-Н12, 2018 оны 1-р сар.

2 ТӨСЛИЙН ТОЙМ

2.1 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Уг төсөл нь зэс, алт, мөнгө, молибдены бүлэг ордоос бүрдэх ба олборлолтоо ил болон гүний уурхайн арга техникийг хослуулан явуулдаг. Төслийн ашиглалтын хугацаа нь баттай болон бодитой нөөцийн хэмжээнд суурилснаар 40 жил (2016 оноос хойш) байна. Өмнөд Оюу, Хюго Даммит орд нь хамтдаа 25.4 сая тонн зэс, 81,600 тонн молибден, ойролцоогоор 5,150 тонн мөнгө, 1,000 тонн алтны нөөцтэй гэж одоогийн байдлаар тогтоогдоод байна. Өмнөд Оюу ордод зэс, алтны Ил уурхай, мөн Гүний уурхай (Хюго Даммит орд) байгуулж олборлолт хийхээр төлөвлөж байна. Баяжуулах үйлдвэрийн анхны зураг төслийн дагуу жилд 35 сая тонн түүхий хүдэр олборлох тооцоонд (нэрлэсэн хүчин чадал нь өдөрт 100,000 тонн) үндэслэж үзвэл жилд 500,000 гаруй тонн баяжмал боловсруулж гаргана.

Ил уурхайг 2012 оны 2-р улиралд энгийн хүнд даацын машин болон экскаватор ашиглан хоногийн 24 цагаар тасралтгүй олборлож эхэлсэн. Тус уурхай нь ил уурхайн дотор талын налууг тогтворжуулах зорилгоор хаданд тэсэлгээ хийж гаргасан хэд хэдэн мөргөцгөөс бүрдэх ба хүдэр, хаягдал чулуулгийг хүнд даацын машинаар зөөх замтай.

Гүний уурхайг блокчлон олборлох аргаар олборлохоор төлөвлөж байгаа ба хүдрийг доороос нь тулж буй чулуулгийг малтаж авснаар хүдэр нь хүндийн хүчний үйлчлэлээр малтлага хийсэн хоосон орон зай руу өөрөө нурж орох замаар олборлоно. Гүний уурхайгаар олборлох арга нь үр ашигтай, өртөг зардал багатайгаас гадна хаягдал шороо чулуу бага гардаг, том хэмжээний хүдрийн биет олборлох боломжтой юм.

Хүдрийг баяжмалд хувиргах процессын загварыг энгийн бутлах, хөвүүлэн баяжуулах технологи, батлагдаж туршигдсан тоног төхөөрөмж ашиглахад үндэслэн гаргасан. Тус процесст анхдагч бутлуураар бутлагдсан том хүдрийн овоолго хийх үйл ажиллагаа орно. Анхдагч бутлуураар буталсан хүдрийг 2.7 км урт газрын гадаргуу дээрх туузан дамжуулагчаар баяжуулах үйлдвэрийн ойролцоо байрлах овоолго руу хүргэж, тэндээсээ хүдрийг жижиглэн бутлах том диаметртай цувраа тээрэм рүү шилжүүлнэ. Хөвүүлэн баяжуулах систем нь зэс агуулсан материалыг дараагийн үе шатанд боловсруулахаар шүүн авах ба флотацын том бассейн дотор шаардлага хангахгүй эрдсийг үнэ цэнэтэй хүдрээс ялгаж авдаг. Энэ зуурлагийг (хаягдал) хоёр өтгөрүүлэгчид 60% хатуу болгож өтгөрүүлээд, Хаягдал хадгалах байгууламжид (ХХБ) шахаж зайлуулдаг. Хаягдал өтгөрүүлэгч болон ХХБ-аас гарсан усыг баяжмал үйлдвэрлэхэд дахин ашиглана. Үүний дараа зэс, алт агуулсан эцсийн бүтээгдэхүүн болох баяжмалыг өтгөрүүлж шүүгээд битүүмжилсэн уутанд хийж савлан, ачааны машинаар Хятад улс руу Гашуунсүхайт/Ганц модны боомтоор дамжуулан тээвэрлэнэ. Гашуунсүхайт хилийн боомт хүртэлх тээвэрлэлтэд дэм болох зорилгоор 2018 оноос зэсийн баяжмалын хоёр орчим хувийг Төслийн талбайгаас зүүн хойно 450 км-т орших Чойрын төмөр замын терминал хүртэл цуваагаар тээвэрлэхээр төлөвлөж байна.

Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны нэмэлт туслах байгууламжид орон нутгийн онгоцны буудал, Хятад улсын хойд хэсэгт орших Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний сүлжээнээс өндөр хүчдэлийн шугамаар дамжуулан авах 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, нүүрсээр галладаг дулааны төв станц (ДТС), ус хангамжийн систем, цэвэрлэх байгууламж, засварын цех, агуулах, захиргааны байр, хог хаягдлын байгууламж, түлш хадгалах байгууламж, захиргааны байр, орон сууц, авто зам, тээврийн дэд бүтэц зэрэг орж байна.

2013 онд ил уурхайгаас олборлолт явуулж эхэлснээр Төслийн ашиглалтын үе шат эхэлсэн. Үүнээс хойш Баяжуулах үйлдвэрээс гарах бүтээгдэхүүний хэмжээ тогтмол өсөж, баяжмалыг Хятадын зах дээлд гаргаж байна. Үйлдвэрлэл явуулж эхэлсэн хоёр дахь жилээс буюу 2015 онд баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулснаар жилийн эцэст үйлдвэрлэлийн хэмжээ үйлдвэрийн нэрлэсэн хүчин чадлаас давсан. 2016 онд 201,300 тонн зэс, 300,000 унци алт, 2017 онд 157,400 тонн зэс, 114,000 унци алт тус тус үйлдвэрлэсэн. 2017 оны 4-р улиралд баяжуулах үйлдвэрийн бүтээмж өмнөх улирлынхаас 2 орчим хувиар нэмэгдсэн. 2017 онд ОТ нийт олборлосон материал болон баяжуулах үйлдвэрт боловсруулсан хүдрийн хэмжээгээр дээд амжилт тогтоосон. Харин бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2016 онтой харьцуулахад буурсан нь

үндсэндээ Ил уурхайн одоогийн олборлолт хийж буй хэсгийн зэсийн агуулга хорин таван хувиар бага, алтны агуулга бараг тавин хувиар бага байгаатай холбоотой. 2018 онд 125,000-155,000 тонн зэс, 240,000-280,000 унци алт бүхий баяжмал үйлдвэрлэх тооцоотой байна.

2013 онд түр зогсолт хийсний дараа гүний уурхайн үйл ажиллагаа 2016 онд Гүний уурхайн төслийг үргэлжлүүлэх хөтөлбөрийн дагуу дахин эхэлж, 2017 онд гүний уурхайн 2-р шатанд шаардлагатай нөөц, хүн хүчээ бүрдүүлж эхэлсэн. Хөндлөн малталт, уурхайн дэд бүтэц, хүдэр олборлох тоног төхөөрөмж, түүзан дамжуургын барилга угсралтын ажлууд бүгд чанарын өндөр түвшинд, аюулгүй урагшилж байна. 2, 5-р босоо амны нэвтрэлт дуусаж, 2-р босоо амны материал тээвэрлэлтийн системийн ажил хийгдэж байна. 5-р босоо амны агааржуулалтын систем бараг дуусаж байгаа ба уг систем ашиглалтад орсноор гүний уурхайн агааржуулалт илэрхий сайжирна. Хөндлөн малталт 10,000 гаруй метрт хүрч, нийт 14,000 метр налуу малталтын 3,000 метрийг хийгээд байна. 3, 4-р босоо амны газар шорооны ажил 2018 оны 1-р улиралд эхэлсэн. Оюут-II кемпийн 8 орон сууцны барилгыг барьж дуусган, ажилчдыг оруулж эхэлсэн. Гүний уурхайн бүтээн байгуулалт, хонгил байгуулах ажлууд дуусмагц уурхайн төлөвлөгөөний дагуу 2020 оноос эхлэн ил уурхайн хүдрийн биетээс гүний уурхайн агуулга өндөртэй хүдрийн биетэд олборлолт хийж эхэлснээр зэсийн үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр нэмэгдэнэ.

Нүүрсээр галладаг Дулааны төв станцын үйл ажиллагааг сайжруулах, баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг өдөрт 100 мянган тонноос дээш баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болгож өргөтгөхтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гараагүй байна. БОНУАТ-нд тусгасны дагуу эдгээрт хоёуланд нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх ёстой юм. 2018 оны 2-р сард МУ-ын Засгийн газар Эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээг цуцалснаа ОТ-д мэдэгдсэн ба ингэснээр Тавантолгойн эрчим хүчний төсөл хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн. Улмаар ОТ-д өөрийн эрчим хүчний эх үүсвэрийг 4 жилийн хугацаанд барьж байгуулах шаардлага тулгарч байна.

2.2 ТАЙЛАНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү тайланг дараах байдлаар бүлэглэн боловсруулав:

- 3-р бүлэг - Зөрчлийн хүснэгт;
- 4-р бүлэг - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн хариуцлагын менежментийн тогтолцоо;
- 5-р бүлэг - Байгаль орчин;
- 6-р бүлэг - Нийгэм;
- 7-р бүлэг - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа;
- 8-р бүлэг - Соёлын өв.

БОНХЗ-ийн хяналт шалгалтаар илэрсэн үндсэн үр дүнг ажиглалт, тайлбар, зөвлөмж хэлбэрээр энэхүү тайланд тусгасан болно. Хоёр төрлийн үр дүнг багтаасан. Үүнд:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө ба/эсвэл СОУТТ-д тодорхойлсон Төслийн үүрэг амлалттай холбоотойгоор илэрсэн Зөрчлийн хураангуйлсан хүснэгт (3-р хэсэг)-д харуулсан зөрчлүүд;
- БОНХЗ-ийн багийн гишүүдийн хамтын мэдлэг, туршлагад үндэслэн тодорхойлж, хэсэг болгоны (4-8) төгсгөлд тусгасан, цаашид авах шаардлагатай арга хэмжээ, нээлттэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөсөн санал зөвлөмжүүд багтаж байна.

БОНХЗ-ийн өгсөн зөвлөмжүүд нь заавал биелүүлэх шаардлага биш тул тэдгээрийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлага тавигдахгүй. Гэсэн хэдий ч БОНХЗ-ийн өгч байгаа бүх зөвлөмжийг ашигтай, ач холбогдолтой талаас нь харж, техник эдийн засгийн талаасаа тохиромжтой бол менежментийн цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Төслөөс хүсэж байна.

3 ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ

Энэ бүлэгт төслийн талбай дээр очиж ажиллах, ОТ төслийн ажилтнуудтай уулзаж ярилцах үеэр ажиглагдсан зүйлс, талбайд ажиллах үед болон хожим бидэнд өгсөн баримт бичигт үндэслэн, мөн бидний ажлын удирдамжтай нийцүүлэн тус тайланд дэвшүүлсэн зөрчил дутагдлыг хүснэгтээр хураангуйлан үзүүлэв.

Тухайн зөрчил дутагдал нь YAMT, БОНМХ, ОТ төслийн хяналт шинжилгээний баримт бичиг, журамд тодорхойлсон ОТ төслийн байгаль орчин, нийгмийн хариуцлагын хувьд хэр ноцтой болохыг тодорхойлох, ОТ төслийн ашиглалтын үйл ажиллагаа нь Зээлдүүлэгч байгууллагуудын Байгаль орчин, нийгмийн холбогдох шалгуурт хэрхэн нийцэж буйг тодорхойлохын тулд хүснэгтийг өнгөөр кодлон ангилсан болно. Өнгөөр кодолсон ангиллыг РТ-ийн ЭМААБООН Менежментийн системийн ангиллын дагуух ОТ төслийн БОНМТ-нд¹¹ тодорхойлсон зөрчил дутагдлын ижил түвшинд үндэслэн оноосон юм.

Дараах байдлаар тайлбарлав:

- **IV ангилал** - Төслийн стандарт, Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн болон нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл, ихээхэн хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулж болзошгүй маш ноцтой зөрчил;
- **III ангилал** - Төслийн стандарт, Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн болон нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл, ихээхэн хор хохирол учруулах эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулах нь тодорхой илрээгүй хэдий ч тийм үр нөлөө үзүүлж болзошгүй бодитой зөрчил;
- **II ангилал** - Төслийн стандарт, Менежментийн төлөвлөгөөг зөрчсөн хэдий ч экологийн болон нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах хэмжээний биш, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулахааргүй бодитой зөрчил;
- **I ангилал** - Төслийн стандарт, Менежментийн төлөвлөгөөг бүрэн дагаж мөрдөөгүй бөгөөд байгаль орчин, орон нутгийн ард иргэд эсвэл ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөл үзүүлэх магадлал байхгүй тохиолдол.

Хэрэгжүүлэх арга хэмжээг үүрэг даалгаврын дугаараар ангилсан ба (үүрэг даалгаврын Х.Ү дугаар) энд Х нь үүрэг даалгаврын дугаар, Y нь хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээний дугаарыг илтгэж байна. Заавар зөвлөмжийг тусгасан текстийг аудит болгоноор хянаж тухайн үеийн нөхцөл байдлыг илүү тодорхой тусган засвар оруулж байх шаардлагатай. Харин анхны дугаарууд нь тухайн үндсэн асуудалд хамаарч байгаа учраас тухайн асуудлыг шийдвэрлэж хаах хүртэл хэвээр үлдэнэ гэдгийг дурдах нь зүйтэй.

Хүснэгтэд тодорхойлсон төсөлтэй холбоотой зөрчил тус бүрт ОТ ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд БОНХЗ дараагийн удаа ажиллахдаа биелэлтийг нь шалгана. Хүснэгтэд мөн илрүүлсэн зүйлсийн тодорхойлолт, оноосон зөрчлийн түвшин, Төслийн хүлээсэн үүрэг хариуцлагад хамаарч буй холбогдох баримт бичиг, мөн БОНХЗ-ийн хамтын мэдлэг түршлага дээр үндэслэн өгч буй засаж залруулах буюу сайжруулах талаарх зөвлөмжүүд багтаж байна. БОНХЗ-ийн үзэж байгаагаар зөрчлийг хангалттай хэмжээнд шийдвэрлээгүй тохиолдолд, нөхцөл байдлаас шалтгаалаад бодит үр дагавраас нь үл хамааран зөрчлийн ангиллыг ахиулж болзошгүй гэдгийг санаж байх хэрэгтэй ба ямар нэгэн засаж залруулах арга хэмжээ авахаас зайлсхийсэн тохиолдолд үндэслэлтэй тайлбар шаардлагатай юм.

Аудитын үр дүнг ерөнхийд нь дараах байдлаар тодорхойлов:

¹¹ Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) - Баримт бичгийн дугаар ОТ-10-PLN-0003в 2013 оны 9 дүгээр сарын 1.

- IV ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- III ангилалд хамаарах 1 зөрчил илэрсэн;
- II ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- I ангилалд хамаарах 3 зөрчил илэрсэн.

Доорх хүснэгтэд БОНХЗ 2013 оны 10-р сард уурхайд ирж аудит хийснээс хойш илэрсэн зөрчлүүдийн төлөвийг нэгтгэн харуулав.

3.1-р хүснэгт: БОНХЗ-ийн илрүүлсэн зөрчлийн төлөв

Даалгаврын д/д	Уурхайд хийсэн аудит	Шинээр илрүүлсэн зөрчил	Хаагдсан зөрчил	Хаагдаагүй зөрчил
M1	2013 оны 10-р сар	26	N.A.	N.A.
M2	2014 оны 4-р сар	11	8	29
M3	Баримт бичгийн аудит 2014 оны 8-р сар	2	3	28
M4	2014 оны 11-р сар	7	10	25
M5	Баримт бичгийн аудит 2015 оны 4-р сар	0	3	22
M6	2015 оны 9 сар	4	6	20
M7	Баримт бичгийн аудит 2016 оны 4-р сар	1	9	12
M8	2016 оны 8-р сар	4	2	14
M9	2017 оны 5-р сар	1	6	9
M10	Баримт бичгийн аудит 2017 оны 10-р сар	0	3	6*
M11	Баримт бичгийн аудит 2018 оны 4-р сар	1	3	4

Тайлбар: Ус, бохир усны менежментэд тусад нь 2017 оны 12-р сард аудит хийгдсэн учраас энэ тайланд ороогүй.

3.2-р хүснэгт: Зөрчлийн хүснэгт

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
Байгаль орчин - Ус, хаягдал усны менежмент							
M2.3	4-р сарын 14 Баримт бичгийн аудит 8-р сарын 14 11-р сарын 14 9-р сарын 15 Баримт бичгийн аудит 2016 оны 4-р сар 8-р сарын 16 2017 оны 5-р сар		УХШТ-нд тусгасан нэмэлт хяналтын цооногуудыг өрөмдөж тоноглох ажлыг хараахан хийгээгүй байна.	Хаагдсан	УХШТ, 3.2.6, 3.3.5-р хэсэг Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө (WR14, WRm06)	Хаагдсан	5.1.2.9-р хэсгийг үзнэ үү. Энэ зөрчил БОНХЗ-ийн 2017 оны 12-р сард хийсэн Усны нарийвчилсан хяналт шинжилгээний үеэр хаагдсан. 2017 оны хээрийн ажлаар ОТ Гүний хоолойн бүсийн 3 цэгт 9 хяналтын цооног өрөмдөж тоногдсон. УХШТ-нд тусгасан хяналтын нэмэлт цооног өрөмдөж тоноглох ажил бүрэн хийгдсэн.
Байгаль орчин - Агаарын чанар							
M1.11	10-р сарын 13 4-р сарын		Том ширхэгтэй хүдрийн овоолгоос их хэмжээний тоос (тоосонцор) ялгардаг. Хөөсөөр	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн	Нээлттэй	5.5.2.1-р хэсгийг үзнэ үү. Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламж тоосжилт ихтэй байсаар ирсэн. Үйл ажиллагаанд хэд хэдэн удаа

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	14 Баримт бичгийн аудит 8-р сарын №7 14 оны 11-р сар Баримт бичгийн аудит 4-р сарын 15 9-р сарын 15 Баримт бичгийн аудит 4-р сарын 16 8-р сарын 16 2017 оны 5-р сар 10-р сарын 17		тоос дарах систем суурилуулсан бөгөөд ажиллуулж байгаа үед ерөнхийдөө сайн үр дүнтэй байгаа. Орчны агаарын чанарт хяналт шинжилгээний илүү нарийвчилсан арга хэрэглэснээр эдгээр арга хэмжээний үр дүнг илүү баримттай тайлбарлах боломжтой болно.		төлөвлөгөө		өөрчлөлт оруулж, хэд хэдэн төрлийн арга хэмжээ хэрэгжүүлснээр Хүдрийн овоолгын байгууламж орчмын агаар дах нийт тоосны нягтрал (TSP) нүдээр харахад багассан харагдаж байна. Тоосжилт буурсныг тоон үзүүлэлтээр нотлохын тулд орчны агаарын хяналт шинжилгээ хийх нь хүндрэлтэй байсан. Учир нь өдийг хүртэл дээжийг сард нэг удаа авч ирсэн ба салхины нөлөө, тухайн үеийн үйл ажиллагааны онцлогоос мөн хамааралтай байдаг. Орчны агаарын чанарыг тасралтгүй үнэлэх шинэ сүлжээ ашигласнаар тоосжилт бууруулах арга хэмжээний үр нөлөөг илүү сайн хянах, тухайн орчин дахь мэдрэг хүлээн авагчдад (голчлон баяжуулах үйлдвэрийн ажилтнууд, Манлай кэмп) үзүүлж буй нөлөөллийг хянах боломжтой болно. ТШХО-ын тоосжилтыг бууруулах чухал арга хэмжээ хэрэгжүүлсэн. Хаалт хийх зэрэг ТШХО-ын доторх тоосжилтыг багасгах бусад арга хэмжээнүүдийг ч авч байна. Үүнээс хамгийн чухал ач холбогдолтой нь “ТШХО-д салхины хүч бууруулах тор худалдан авч суурилуулах” төсөл бөгөөд 2018 оны 3, 4-р улиралд дуусна. Уг төслийн үр дүнд ТШХО орчмын тоосжилт, салхины нөлөө бодитоор буурах төлөвтэй байгаа. Цаашдын хяналт шинжилгээний дүн, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт зэргээс хамааран энэ зөрчлийг хаана.
M1.12	10-р сарын 13		Одоо ашиглаж байгаа орчны агаарын хяналт шинжилгээний сүлжээ учир дутагдалтай байна.	Хаагдсан	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн	Хаагдсан	5.5.2.1. хэсгийг үзнэ үү. Өмнөх аудитын тайлангуудад тэмдэглэсэнчлэн шинэчилсэн АЧХШТ-нд заасан үүрэг амлалтаа биелүүлж, орчны агаарын чанарыг Төслийн

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	4-р сарын 14 Баримт бичгийн аудит 8-р сарын 14 11-р сарын 14 Баримт бичгийн аудит 4-р сарын 15 9-р сарын 15 Баримт бичгийн аудит 4-р сарын 16 8-р сарын 16 2017 оны 5-р сар 10-р сарын 17		Орчны агаарын чанарыг Төслийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан хянахын тулд нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах шаардлагатай талаар АЧМТ-нд дурджээ.		төлөвлөгөө - (ГГҮ02 Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө-2.5, 4.1-р хэсэг Хавсралт, В)		шалгуур үзүүлэлттэй харьцуулан хянахын тулд орчны агаарын чанарын хяналтын сүлжээг сайжруулах шаардлагатай байна. Одоогоор систем хэвийн ажиллаж, байнгын хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулж байна. Орчны агаарын чанарын үзүүлэлт стандартаас хэтэрсэн тохиолдол гарсан хэдий ч хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд эрсдэл учруулах хэмжээнд хүрээгүй.

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
M1.13	10-р сарын 13 4-р сарын 14 Баримт бичгийн аудит 8-р сарын 14 11-р сарын 14 Баримт бичгийн аудит 4-р сарын 15 9-р сарын 15 Баримт бичгийн аудит 4-р сарын 16 8-р сарын 16 2017 оны 5-		Дулааны төв станцын (ДТС) болон Ханбогдын нисэх онгоцны буудалд ашиглаж буй уурын зуухны утаанаас авсан дээж төслийн стандартыг хангаж чадахгүй байна.	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө (AM03) Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө - Б хавсралт)	Нээлттэй	5.5.2.2-р хэсгийг үзнэ үү. ДТС-ын утааны чанарын үзүүлэлт Төслийн стандартад хүрсэн удаа үгүй бөгөөд энэ асуудал байнга тавигдсаар ирсэн. Станцын утаанд хяналт шинжилгээ хийсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр утаанаас дээж авахад хэрэглэж байгаа аргачлалд хэд хэдэн дутагдалтай тал байгааг илрүүлсэн. АЧХШТ-ний шаардлагын дагуу ДТС-ын хүчин чадлыг 130 мВт болгох 2 дахь шатны өргөтгөлийн ажлын хүрээнд Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС)-ийг үндсэн нэг янданд суурилуулна. ОТ хамгийн сайн боломжит технологийг төслийн стандартуудад нийцүүлэн хэрэглэж байгаа тул энэ зөрчлийг 1-р ангиллын зөрчил болгон бүүруулсан. Гэхдээ Өөрчлөлтийн тэмдэглэл 2017-001-ээр батлагдсан төслийн өөрчлөгдсөн стандартад заасан тоон босгоор тодорхой илэрхийлэгдсэн мэдээллийг Утааны тогтмол хяналт шинжилгээний системээс гарган авна.

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	р сар 10-р сарын 17						
Байгаль орчин - Биологийн олон янз байдал, экологийн менежмент							
M11.2	2018 оны 4-р сар		Ховор ургамлын зүйлд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх	III ¹²	ГХЗ-ийн журам; БОЯБУАТ; БОЯБҮМХ	Нээлттэй	5.9.2.4-р хэсгийг үзнэ үү. БОННУ-ий биологийн төрөл зүйлийн менежмент, нөлөөлөл бууруулах үүрэгт заасны дагуу Чухал амьдрах орчинд багтсан төслийн нөлөөллийн бүс дэх 4 ховор ургамлын зүйлд эерэг нөлөө ахиу үзүүлэх, Байгалийн амьдрах орчинд багтсан 4 ховор ургамлын зүйлд алдагдал учруулахгүй байх үүргийг ОТ хүлээсэн. Энэ зорилтын хэрэгжилтийг дүгнэх хугацаа, уурхайн ашиглалтын хугацаа хоёр 2036 онд давхцаж байгаа. Гэхдээ уурхайн ашиглалтын хугацааг 2055 он хүртэл сунгаж магадгүй байгаа. Нөлөөлөл шатлан бууруулах аргачлалын дагуу а)

¹² Грубовын хөөндийг нөлөөлөлд өртөхөөс хамгаалах, үржүүлэхтэй холбоотой БОНХЗ-ийн байр суурь, үүнийг 3-р ангиллын зөрчилд хамааруулсан талаар хэлэлцсэний дараа ОТ дараах зүйлд үндэслэн уг зөрчлийг эсэргүүцэж байна. Бүтээн байгуулалтын хугацаанд ховор ургамалд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар БОННУ-нд тодорхойлсон ба төслийн бүтээн байгуулалтын шатанд эерэг нөлөө ахиу үзүүлэх үүрэг хүлээгээгүй. Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0005), Ховор ургамал хамгаалах журамд (ОТ-10-Е14-PRC-007) Грубовын хөөндийг зэрэг ховор ургамалд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулахын тулд нөлөөлөл шатлан бууруулах үйл явцыг ашиглана гэж заасан. Уг баримт бичгүүдэд дурдсан бүх шаардлагыг ОТ бүтээн байгуулалтын болон ашиглалтын үйл ажиллагаандаа мөрддөг. Ховор ургамал хамгаалах журамд нөхөн сэргээлтэд ашиглах ургамлын төрөл зүйл үржүүлэх өөр арга боловсруулах судалгаа хийх шаардлагатай гэж заасан ба уг судалгааг Грубовын хөөндийг болон өөр 2 ховор төрөл зүйлийг хамруулан хийж байна. ОТ боловсруулж гаргасан журмуудаа мөрдөж ажилладаг ба Грубовын хөөндийд (бусад ховор төрөл зүйл) үзүүлж буй нөлөөллийг бууруулах үүргээ бүтээн байгуулалтын сүүлийн үе шат болон ашиглалтын үйл ажиллагаандаа мөрдөх болно.

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>ургамал, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх буюу хамгаалах, б) зайлсхийх боломжгүй бол өөр газар шилжүүлэн тарих (шилжүүлэн тарих ажиллагаанд тухайн зүйл тохиромжтой эсэхийг судлах), в) шинэ ургамлын төрөл зүйлийг үр, суулгацаар үржүүлэн тарих, эсвэл тохиромжтой нөхцөл, байршилд тухайн ургамлыг дахин үржүүлэх байдлаар цэвэр эерэг нөлөөлөл бий болгодог.</p> <p>Өмнөх аудитаар ховор ургамлын зүйл хамгаалах ажлыг үр дүнд хүргэх, Нутгийн ургамал үржүүлгийн төвийн ховор ургамлын төрөл зүйлийг үржүүлэх чадамжийг сайжруулах талаар Зээлдүүлэгчдийн санаа зовниж байсан. Ургамал нь шилжүүлэн суулгасны дараа үхэх магадлал өндөр байдаг ба төлөвлөгөөний дагуу хөндсөн газруудад арчилж тордох, нөхөн сэргээх найдвартай арга техник байхгүй байна. Үүний тод жишээ бол төлөвлөгөөний дагуу хөндсөн газруудтай давхацсаны улмаас аюулын статус нь нэмэгдэж буй Грубовын хөөндий юм.</p> <p>Энэ бүхнийг анхааран ОТ ховор ургамал хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд 6 үйл ажиллагаа буюу төсөл боловсруулсан.</p> <p>2017 оны 10-р сараас хойш 200 орчим га-д ГХЗ олгожээ. Дээрх төслүүдийн хэрэгжилт сайн байгаа төдийгүй 4-р босоо амны байршил дахь Грубовын хөөндийн популяцын заримыг (Газар хөндөх бүртгэлийн төлөвлөгөөний бүртгэлийн хуудас болон дэд бүтцийн өөр талбай судлах замаар) нөлөөлөлд өртүүлэлгүй хамгаалж чадсан хэдий ч 2800 бодгаль</p>

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>дэд бүтцийн нөлөөлөлд өртсөний улмаас НУУТ-д шилжүүлэн суулгасан.</p> <p>Грубовын хөөндийтэй холбоотой БОНХЗ-ийн өгсөн зөвлөмжийг ОТ хэрэгжүүлэн, бодитой ахиц дэвшил гаргасныг зөвлөх цохон тэмдэглэж байна. Тухайлбал а) томоохон хэмжээний хээрийн судалгаа хийж, тухайн бүс дэх Грубовын хөөндийн популяц, тархалтыг нэлээд их хэмжээгээр илрүүлжээ. б) Грубовын хөөндийн ховордлын зэргийн статусыг дахиж үнэлэн, хурдан үржүүлгийн арга хэрэглэх талаар МУИС-тай хамтран ажиллаж байна.</p> <p>Гэсэн хэдий ч БОНХЗ ховор ургамлын төрөл зүйлд (ялангуяа Грубовын хөөндий) учирсан нөлөөллийг харгалзан уг зөрчлийг III ангиллын зөрчилд оруулсан. Сүүлийн аудитаас хойш 2800 бодгальд (энэ нь уурхайн лицензийн талбай дахь популяцын 20 гаруй хувь) учирсан нөлөөлөл болон Грубовын хөөндийн үржүүлэг, шилжүүлэн суулгалт, нөхөн сэргээлт амжилттай болсныг батлах нотолгоо хангалтгүй байгаа тул Зээлдүүлэгчдийн шаардлагын (PS6, PR6) дагуу эерэг нөлөө ахиу үзүүлэх баталгаа хангалтгүй байна. ОТ Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөнийхөө дагуу үүнийг Зээлдүүлэгчдийн шаардлагад (PS6, PR6) нийцүүлэх үүрэгтэй.</p> <p>Дээрх нөлөөллөөс уурхайн талбай дахь популяц хорогдсон ба одоогоор нөхөн сэргээх аргыг тодорхойлоогүй байна.</p>
M8.2	8-р сарын	2018 оны	Автозамын нөлөөлөл бууруулах	I	БОЯБУАТ (13)	Хаагдса	5.9.2.5-р хэсгийг үзнэ үү. ОТ нь а) автозам хаах, замын

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	16 2017 оны 5-р сар 10-р сарын 17	4-р сар	стратеги			н	<p>хөдөлгөөний хязгаарлалт тогтоох, б) бүсийн түвшний тогтвортой хөгжлийн асуудалтай холбоотой нөлөөлөл бууруулах тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх тал дээр холбогдох байгууллага, эрх бүхий этгээдүүдтэй албан ёсоор хамтран ажиллах, в) ОТ-Гашуунсүхайд чиглэлийн зам, бусад ОТ-н эзэмшлийн бус зам дээр замын хөдөлгөөний хяналт тавих, тэдгээрийн ан амьтдад үзүүлэх нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх зэрэг асуудлуудыг тусгасан ОТ-Гашуунсүхайд чиглэлийн замын нөлөөлөл бууруулах стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг авсан.</p> <p>Хар сүүлт зээр, хуланд зэрэг нөлөө ахиу үзүүлэх хамгийн шилдэг арга бол биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх юм гэж Замын нөлөөлөл бууруулах зөвлөлөөс ОТ-д зөвлөсөн.</p> <p>GPS хүзүүвчийн тусламжтайгаар эдгээр түүрайтан амьтдын шилжилт хөдөлгөөнийг хянах ажлаа үргэлжлүүлэхийг тус зөвлөл мөн зөвлөсөн. Хар сүүлт зээрийн талаар судалгааны мэдээлэл дутмагаас гадна нөлөөлөлд илүү их өртөж байгаа тул онцгой анхаарах хэрэгтэй гэв. ОТ 2018 оны 9-10 сард нэмж 20 GPS хүзүүвч зүүхээр төлөвлөж байна.</p> <p>2018 оны 1-р улиралд боловсруулсан ОТ-н Автозамын нөлөөлөл бууруулах стратегийг Зээлдүүлэгчид баталсан тул уг зөрчлийг хаав.</p>
Нийгэм-Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, амьжиргаа сайжруулах							

Үүрэг / асуудлын д/д	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
M1.23	10-р сарын 4-р сарын 14 8-р сарын 14 11-р сарын 14 4-р сарын 15 9-р сарын 15 4-р сарын 16 8-р сарын 16 5-р сарын 17 10-р сарын 17 2018 оны 4-р сар		Нөлөөлөлд өртсөн малчдад чиглэсэн хөтөлбөрүүдэд Үр дүнгийн үнэлгээ хийх нь Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан үүрэг бөгөөд Ханбогд сумын эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн болон бусад нөлөөлөлд өртсөн малчдыг хамарсан үр дүнгийн үнэлгээ хийх хугацаа болсон байна.	I	Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (10.1, 10.2, 10.4)	Нээлттэй	6.3.2.2-р хэсгийг үзнэ үү. ОТ 2017 оны 10-р сард “Интерсошл консалтинг” компанитай Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн тухай бүлэгт үр дүнгийн үнэлгээ хийх гэрээ байгуулсан. Үнэлгээг 2017 оны 11-12 дугаар сард хийсэн ба үнэлгээний хүрээнд хээрийн судалгаа хийсэн. Үр дүнгийн үнэлгээний төслийг дотооддоо хянасны дараа 2017 оны 5-р сард Зээлдүүлэгчид болон БОНХЗ-д явуулсан ба тэдний саналыг тусгаад эцэслэн гаргах ажил хийгдэж байна. Өмнөх аудитаар Олон талт шинжээчдийн баг (ОТШБ) - ийн судалгаа хийгдэж, 2017 оны 1-р улиралд дууссан байсан. Бодитой ажлууд хийгдэж, ахиц гарсан ч энэ тайланд үр дүнгийн үнэлгээг авч үзсэнгүй. Ханбогдын нөлөөлөлд өртсөн малчдын дунд үр дүнгийн үнэлгээ хийх ажлын явц ихээхэн хойшлогдсоор ирсэн бөгөөд дээрх судалгааны дүнг хугацаанд нь гаргах нь чухал байна. БОНХЗ талууд амжилтад хүрсэн эсэхийг хэмжих үзүүлэлт буюу ‘үр дүн’-д хүрсэн гэж үзэх үзүүлэлтийг харилцан тохиролцсоноор яваандаа эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой зөрчлийг хаахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж зөвлөснөө энэ удаа дахин давтаж хэлмээр байна. Үр дүнгийн үнэлгээг амжилттай хийж дуусах хүртэл энэ зөрчил нээлттэй байна.

